



ОУХБ Япон улсын
олон/хоёр талт хамтын
ажиллагааны хөтөлбөр



Нийгмийн даатгалын
ерөнхий газар




Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага

НИЙГМИЙН ДААТГАЛ

МАЛЧДАД ЗОРИУЛАВ



УЛААНБААТАР 2016



ОУХБ Япон улсын
олон/хоёр талт хамтын
ажиллагааны хөтөлбөр



Нийгмийн даатгалын
ерөнхий газар



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага

НИЙГМИЙН ДААТГАЛ

МАЛЧДАД ЗОРИУЛАВ

УЛААНБААТАР 2016

ТАНИХ ТЭМДЭГ



Уншаарай



Бичээрэй, зураарай



Сонсоорой



Хамтран ажиллаж,
харилцан ярилцаарай



Бодоорой



Ажиглаарай



Асуугаарай



Санамж

НИЙГМИЙН ДААТГАЛ

Малчдад зориулсан бие даан суралцах гарын авлага

Боловсруулсан:

Д.Нарантуяа, Г.Энхбилэг,

А.Лхагвадэмбэрэл

Хянан тохиолдуулсан:

Д.Мэндбаяр, Б.Батбаатар,

Ц.Ганцэцэг

Бие даан суралцах арга зүйг боловсруулсан: Д.Гүндэгмаа

Зураач:

Г.Амарсанаа

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн:

Д.Гүндэгмаа

АГУУЛГА

Нэг. Оршил	4
Хоёр. Нийгмийн даатгал	6
2.1. Нийгмийн даатгал, түүний ач холбогдол	7
2.2. Нийгмийн даатгалын төрөл ба сан	9
2.3. Малчин нийгмийн даатгалд яаж даатгуулах вэ?	13
2.4. Тэтгэврийн даатгал	18
2.5. Тэтгэмжийн даатгал	29
2.6. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал	33
Гурав. Эрүүл мэндийн даатгал	37
3.1. Эрүүл мэндийн даатгал, түүний ач холбогдол	37
3.2. Малчин эрүүл мэндийн даатгалд яаж даатгуулах вэ?	39
3.3. Эрүүл мэндийн даатгалд хамаарах тусламж, үйлчилгээ, зардлын төлбөр	41
Дөрөв. Хавсралт	
4.1. Тэжээгчээ алдсаны тэтгэврийг хэн авах вэ?	48
4.2. Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах гэрээний загвар	49
4.3. Өөрийгөө үнэлэх асуулгын хариу	54
4.4. Сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр	56
4.5. Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын талаар мэдээлэл авах эх сурвалж	58

НЭГ. ОРШИЛ

Монгол Улсын эдийн засаг, хүн амын хөдөлмөр эрхлэлтэд мал аж ахуй томоохон байр суурь эзэлдэг. Дотоодын нийт бүтээгдэхүүний 10 гаруй хувийг мал аж ахуйн үйлдвэрлэл, хөдөлмөр эрхэлж байгаа хүн амын 30 орчим хувийг малчид эзэлдэг бөгөөд нийт өрхийн 20 орчим хувь нь зөвхөн мал аж ахуйн орлогоор амьдарч байна.

Төрөөс малчдын амьдрал, аж ахуй, ажил хөдөлмөрийн онцлог, хэв шинжид нийцсэн нийгмийн хамгааллын бодлого хэрэгжүүлж, орлогын баталгааг нь хангахад нийгмийн даатгал чухал үүрэгтэй. 2015 оны байдлаар нийт малчдын 10,4 хувь нь нийгмийн даатгалд, 42 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна. Энэ нь ирээдүйд 10 малчин тутмын 9 нь өвчлөх, бэртэх, гэмтэх, хөдөлмөрийн чадвараа түр болон удаан хугацаагаар алдах, хүүхэд төрүүлэх, өтөлж хөгшрөх үедээ орлогын баталгаагүй үлдэх эрсдэл дагуулж байна. Тиймээс ч нийгмийн даатгалын үйлчилгээг малчин та бүхэнд ойртуулах, хэрэгцээ, боломжид тань илүү нийцүүлэхэд чиглэсэн зарим өөрчлөлтийг хууль тогтоомжид тусган хэрэгжүүлж эхлээд байна.

Малчин таны нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, ач холбогдол, давуу талыг нь таньж мэдэхэд туслах зорилгоор энэхүү гарын авлагыг боловсруулан хүргэж байна.

Тус гарын авлага нь оршил, 2 бүлэг, хавсралтаас бүрдэж байгаа бөгөөд бүлэг бүр нь зорилго, мэдээлэл(агуулга), дасгал даалгавар, өөрийн үнэлгээ гэсэн доорх зурагт үзүүлсэн бүтэцтэй болно.



ГАРЧИГ

1. Оршил
.....
2. Нийгмийн даатгал
.....
3. Эрүүл мэндийн даатгал
.....
4. Хавсралт
.....

СЭДЭВ БҮРИЙН БҮТЭЦ

Зорилго: _____

Мэдээлэл: _____

Дасгал, даалгавар _____

Өөрийн үнэлгээ _____

Суралцаж эхлэхээсээ өмнө гарын авлагын эхэнд буй таних тэмдгүүдтэй танилцаарай. Таних тэмдгүүд нь Танд унших, ажиглах, хамтран ажиллах, эргэцүүлэн бодох, асуултад хариулах зэрэг үйлийн алийг хийх талаар мэдээлэл-дохио өгнө.

Суралцагч Та гарын авлагаараа хичээллэж байхдаа Ганаа, Болороо, Хангай, Насан нарын яриаг сайтар анхааран уншаад, тэдний ярилцлагаас санаа авч гэртээ яриа өрнүүлэн, сурч байгаа зүйлдээ гэр бүлийнхнийхээ анхаарлыг татахыг хичээгээрэй.

Өмнө харуулсан бүтцийн дагуу сэдэв бүрийн эхэнд эхлээд зорилгыг тодорхойлсон. Зорилготой танилцаад тухайн сэдвийн үндсэн мэдээллийг уншиж судална. Дараа нь бие даан гүйцэтгэх дасгал, даалгаврыг хийнэ. Бие даан гүйцэтгэх дасгал, даалгаварт бичиж тэмдэглэх, тооцоолох, эргэцүүлэн бодох, шийдвэрлэх ажлууд бий. Тэдгээрийг удирдамж зааврын дагуу гүйцэтгээрэй.

Гарын авлагын гол баатар Ганаа, Болороо хоёрын жишээгээр тусгай дэвтэр гаргаж, гарын авлагынхаа зураг, жишээ, зарим бодож тооцох дасгалын загвар, санамж зэргийг хувиалан авч наагаад зурагтай бяцхан ном бүтээгээрэй. Өөрийнхөө бүтээсэн номыг мэдлэгээ сэргээн санах, бусдад ярьж түгээхэд ашиглаж байгаарай. Энэ нь бие даан суралцаж байна гээд гарын авлагаа зүгээр нэг уншаад өнгөрөх биш эргэж харах юмтай, бүтээсэн бүтээлтэй үлдэх хамгийн бүтээлч ажил болохоор Та заавал хийгээрэй.

Сурсан зүйлээ та өөрөө үнэлнэ. Бид "өөрийгөө үнэлэх" маш энгийн аргыг танд зориулж боловсруулсан байгаа. Сэдэв бүрийн дараа өөрийгөө үнэлэх хүснэгт болон арга бий. Хүснэгтэд буй өгүүлбэрүүдийг уншаад "тийм", "үгүй", "мэдэхгүй" гэсэн хариунаас өөрийнхөө хариултыг сонгон будна. Тэгээд номынхоо ард буй хариуны хүснэгттэй тулгаж үзээрэй. Үнэлгээний хүснэгтийн доорх зааврын дагуу та тухайн сэдвийг хэр зэрэг ойлгож мэдсэнээ үнэлж, шаардлагатай бол сэдвээ дахин судлаарай.

Мөн сурсан зүйлээ бусдаар үнэлүүлэх, санал сэтгэгдлийг нь сонсох, санаа авах, бие даан суралцаад би ямар үр дүнд хүрэв гэдгээ эргэн харж эргэцүүлэн бодох асуулга чиглүүлэг ч байгаа. Тэр бүхнийг анхааралтай уншиж ашиглаарай.

Энэхүү гарын авлагаар бие даан суралцаад, Та олон зүйлийг сурах болно.
Амжилт хүсье!

ХОЁР. НИЙГМИЙН ДААТГАЛ

Зорилго: Энэхүү сэдвийг судлах явцад Та:

- Нийгмийн даатгал, түүний ач холбогдол, нийгмийн даатгалын төрөл, сан
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын талаар ойлголттой болж, сайн дураар хэрхэн даатгуулахаа мэдэж авна.
- Мэдлэгээ хэрэглэх дасгал, даалгавар гүйцэтгэнэ.
- Сурсан зүйлээ өөрөө үнэлнэ.



Хангай: - За хө, сайхан сур болох нь дээ. Хөгшин чинь чамаас туршлага судлана байгаа.

Ганаа: - Тэг л дээ. Чи хаа хүрч явна даа?

Хангай: - Сумын төв орж нийгмийн даатгалын шимтгэлээ төлөх гээд л.

Ганаа: - Би чамаас асууя гэж бодоод л завдахгүй байсан юм. Нийгмийн даатгалд мөнгө төлөөд ямар ашиг байна аа?

Хангай: - Сувдаа бид хоёр ч сайн дурын даатгалд даатгуулаад удаж байна. Нийгмийн даатгал бидэнд хэрэгтэй шүү. Чи сумын нийгмийн даатгалын байцаагч Насангаас сайн асуугаарай. Хоёулаа хамт явах уу?

Ганаа: - Өнөөдөр амжихгүй нь, хө. Чи орж цай уугаач.

Хангай: - Яарч явна, хө. Дараа ууяа.



- Ганаа, хоёулаа өчигдөр сумаас явуулсан нийгмийн даатгалын тухай номыг үзье. Гоё ном байна лээ.

- Тэгье хө. Тэр өгөөд байдаг номнууд чинь их зүгээр юм байна лээ. Тэнд нийгмийн даатгалын тухай тодорхой байгаа байх аа...




2.1. Нийгмийн даатгал, түүний ач холбогдол

Нийгмийн даатгал гэж төр, ажил олгогч болон даатгуулагчийн төлсөн шимтгэлээр сан бүрдүүлж, уг сангаасаа даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, жирэмсний болон амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох замаар орлогын баталгааг нь хангах арга хэмжээ юм.



Нийгмийн даатгал өлгийтэй нялхсаас өтгөс буурал хүртэлх бүх хүмүүсийн амьдралд ач тустай.

Хүний амьдралд тохиолдож болох жам ёсны болоод гэнэтийн дараах эрсдэлийн үед нийгмийн болон эрүүл мэндийн даатгал Танд болон танай гэр бүлд учрах санхүүгийн хүндрэлийг даван туулахад тань тусална.



Өндөр наслах



Жирэмслэх, амаржих



Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах



Ажилгүй болох



Хөдөлмөрийн чадвараа түр алдах



Нас барах



Тэжээгчээ алдах



Хөдөлмөрийн чадвараа байнга буюу удаан хугацаагаар алдах

Зураг 1. Нийгмийн даатгалд хамрагдах тохиолдол (эрсдэл)



Өмнөх зургийн дагуу ярилцаарай. Чиглүүлэг:

- а. Зураг 1-т харуулсан эрсдэл бүрийн тохиолдож болох магадлалыг өөрсдийн ахуй амьдрал, гэр бүлийн жишээн дээр авч ярилцана.
- б. Мөн малчдын хувьд нийтлэг тохиолдож болох байгаль цаг уурын, эдийн засгийн болон нийгмийн шинжтэй ямар эрсдэл байдаг, тэдгээр нь нийгмийн даатгалд хамрагдах тохиолдлуудтай хэрхэн холбогдож болохыг дараах загварыг ашиглан ярилцаарай. Жишээ нь, цасан шуурганд малаа уруудуулсан малчин малаа дагаж яваад, хөлөө хөлдөөж, хөдөлмөрийн чадвараа түр хугацаанд алдвал нийгмийн даатгалтай холбогдох уу, та юу гэж бодож байна вэ?

Эрсдэл	Хохирол (даатгалын тохиолдол)	Нийгмийн даатгалд хамрагдах эсэх
Байгалийн гамшигт үзэгдэл (зуд, үер, ган, гал түймэр гэх мэт) болох	Мал хорогдох	Үгүй
	Гэр оронгүй болох	Үгүй
	Өвчлөх, бэртэх гэмтэх, осгох	Тийм
...		



- Эрсдэл хэзээ ч, хэнд ч учирч болно.
- Эрсдэл тохиолдвол хүн эрүүл мэнд, орлого, эд хөрөнгийн хохирол, алдагдал хүлээх болно. Эрсдэлийг шилжүүлж, түүнээс учрах хохирлыг бууруулах аргын нэг нь даатгал юм.

Зураг 1-т үзүүлсэн тохиолдлуудад нийгмийн даатгал таныг хэрхэн хамгаалах вэ?

- Тэтгэвэр
- Тэтгэмж
- Төлбөр, зардал олгоно.

Нийгмийн даатгалаас эдгээр үйлчилгээг авахын тулд малчин Та:

1. Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулж шимтгэл төлнө.
2. Хууль тогтоомжид заасан нөхцөл болзлыг хангасан байна. Жишээ нь, ердийн өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдахаас өмнө тэтгэмжийн даатгалын шимтгэлийг 3-аас доошгүй сар төлсөн бол уг сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж авна.



- Нийгмийн даатгал гэхээр өндөр насны тэтгэвэр л гэж боддог байлаа. Үгүй юм байна шүү дээ ...

- Тийм байна, хө. Би тэтгэвэрт гартал хаа ч юм гээд хайхардаггүй байсан. Даатгуулах хэрэгтэй юм байна. Юу ч тохиолдоо билээ ...



- Яг зөв. Би ч бас тэгж бодож байна. Би хэрэв даатгуулсан байсан бол өнгөрсөн жил олгой авахуулаад эмнэлэгт хэвтсэн хугацаандаа тэтгэмж авах байсан юм байна. Аймгийн төвд очиж эмнэлэгт хэвтэхэд ямар их зардал гарсныг санаж байгаа биздээ. Азаар эрүүл мэндийн даатгалтай байсан нь яамай.

Малчид нийгмийн даатгалд даатгуулах нь ямар ач холбогдолтой вэ?



Малчид нийгмийн даатгалд хамрагдаж, хуульд заасан болзол хангасан тохиолдолд өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвар түр алдсаны, оршуулгын тэтгэмж авч **өөрийн болон гэр бүлийн гишүүдийнхээ орлогын баталгааг** хангана.

2.2. Нийгмийн даатгалын төрөл ба сан

Нийгмийн даатгал нь 5 төрөлтэй бөгөөд төрөл тус бүр нь бие даасан мөнгөн хөрөнгийн сантай байдаг (Зураг 2).



Зураг 2. Нийгмийн даатгалын төрөл

Нийгмийн даатгалын санг хэрхэн бүрдүүлдэг вэ? Нийгмийн даатгалын сангийн орлого дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ.Үүнд:

- Даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл;
- Ажил олгогчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл;
- Сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү, үнэт цаасны арилжаанаас олсон орлого;
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэнд оногдуулсан алданги;
- Улсын төсвөөс олгох хөрөнгө;





Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг зөвхөн:

- тэтгэвэр, тэтгэмж олгох;
- нийгмийн даатгалын байгууллага, үндэсний болон салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх;
- хууль тогтоомжид заасан бусад төлбөр, зардлыг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд зориулалтын бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглодог.

Нийгмийн даатгалын сангаас ямар тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгодог вэ?



Тэтгэврийн даатгалын сангаас:

- Өндөр насны тэтгэвэр
- Тахир дутуугийн тэтгэвэр
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр



Тэтгэмжийн даатгалын сангаас:

- Жирэмсний болон амаржсаны тэтгэмж
- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж
- Оршуулгын тэтгэмж



Эрүүл мэндийн даатгалын сангаас:

- Даатгуулагчид үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардал
- Рашаан сувиллын тусламж, үйлчилгээний зардал
- Эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх зардал



Ажилгүйдлийн даатгалын сангаас:

- Ажилгүйдлийн тэтгэмж
- Мэргэжил олгох болон давтан сургалтын зардал



**Үйлдвэрлэлийн осол,
мэргэжлээс шалтгаалсан
өвчин(ҮОМШӨ)-ий
даатгалын сангаас**

- Тахир дутуугийн тэтгэвэр
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр
- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж
- Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр
- ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл
- Сувиллын зардал

Зураг 3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр



- Малчид бид нийгмийн даатгалд даатгуулдаггүй болохоор энэ олон төрлийн тэтгэвэр, тэтгэмж авах боломжийг алддаг юм байна шүү дээ ...

- Нийгмийн даатгал ер нь зүгээр юм шиг байна аа, хө. Өвчин зовлон тохиолдох бүрт хэдэн малаараа аргалаад байх боломжгүй юм байна. Ойрын үед сумын байцаагчтай уулзъя байз. Малчид заавал сар бүр даатгалын шимтгэлээ төлөхгүй, орлоготой сардаа бөөнөөр нь төлж болно гээд байгаа ...



Та Болороогийн бодолтой санал нийлж байна уу?



Өтлөх нь жам юм хойно
Өнөөдрөөс л анхаарах
хэрэгтэй юм байна даа ...





Ганаагийн яриаг уншаад, ярилцаарай.



Малчин Ганаа 32 настай мал маллаад зургаан жил болж байна. Тэрээр эхнэр, 2 хүүхэдтэй, сар бүрийн орлого нь тогтмол биш боловч жилийнхээ орлогыг сард хуваан тооцвол 900 000 орчим төгрөг. Найман жилийн өмнө нийгмийн даатгалын дэвтэр нээлгэсэн ч одоо болтол шимтгэл төлөөгүй. Тэрээр хэлэхдээ, “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх санхүүгийн боломжтой ч өнөө маргаашдаа амьдрал маань болоод л байгаа болохоор үнэндээ нэг их ач холбогдол өгөхгүй байна. Надтай адил олон малчин залуу нийгмийн даатгалгүй. Тэд ч гэсэн одоохондоо дутагдаж гачигдах зүйлгүй амьдарч байгаа учир нийгмийн даатгалд хамрагдъя гэж боддоггүй байх. Тэтгэвэрт гарах болоогүй, одоо төллөө гээд хэзээ ашгийг нь хүртэх билээ гэж ихэнх залуучууд боддог” гэлээ.

Чиглүүлэх асуулт:

- Танай нутгийн малчид нийгмийн даатгалд сайн дураар даатгуулдаг уу?
- Нийгмийн даатгалыг Ганаа шиг ойлгодог залуус байдаг уу?
- Нийгмийн даатгал нь зөвхөн тэтгэвэрт гарахад бэлтгэх асуудал мөн үү?
- Нийгмийн даатгал иргэнийг эрсдэлээс хамгаалж, нийгмийн баталгааг нь хангадаг гэдгийг Та тайлбарлаж чадах уу?



Өөр нэг жишээг уншаад, нийгмийн даатгалын ач холбогдлын талаар ярилцаарай.



Иргэн “А”, түүний нөхөр хоёр 2007 оноос хойш сайн дураараа даатгуулжээ. Нөхөр нь өнгөрсөн жил мориноос унаж, хөлөө гэмтээхдээ үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэмж авчээ. Хоёр оюутан хүүхэд нь ч бас даатгуулсан, оюутны 70,000 төгрөгөө аваад нийгмийн даатгалын шимтгэлээ төлдөг. Оюутан охин Энхээ нь одоо 8 сартай жирэмсэн. Тэр сүүлийн 2 жил нийгмийн даатгалын шимтгэлээ төлсөн учраас жирэмсний болон амаржсаны тэтгэмжид 532 528 төгрөг авна.

Чиглүүлэх асуулт:

- Танай болон төрөл садангийн чинь хүүхдүүдээс их, дээд сургууль, коллежийн оюутан байгаа юу?
- Хэрвээ байгаа бол нийгмийн даатгалын шимтгэлээ төлдөг болов уу, та мэдэх үү?
- Хэрвээ таны мэдэх оюутан нийгмийн даатгалын шимтгэлээ төлдөггүй бол та юу гэж зөвлөх вэ?
- Оюутан нийгмийн даатгалд малчны нэгэн адил сайн дураар даатгуулна. Хамгийн доод хэмжээгээр төлөхөд сард 23 040 төгрөг төлнө.

2.3. Малчин нийгмийн даатгалд яаж даатгуулах вэ?

Нийгмийн даатгал нь *албан журмаар болон сайн дураар даатгуулах* гэсэн хоёр хэлбэртэй байдаг. Албан журмын даатгуулагчийг өмнөх хэсэгт үзсэн 5 төрлийн даатгалд ажил олгогч нь хамруулдаг.

Харин аймаг, дүүрэг, сумын нийгмийн даатгалын байцаагч нь иргэдэд нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдлыг тайлбарлан таниулж, тэдгээрийг сайн дурын даатгалд даатгуулахад зөвлөж туслах үүрэг хүлээдэг.

Сайн дурын даатгалд тэтгэврийн, тэтгэмжийн, ҮОМШӨ-ний даатгал багтана.



Малчин Та нийгмийн даатгалд сайн дураар даатгуулна. Та даатгуулах гэж байвал эхлээд нийгмийн даатгалын байцаагчтайгаа уулзаарай.

Нийгмийн даатгалд малчдаас гадна дараах иргэд сайн дураар даатгуулна. Үүнд:

- Хувиараа хөдөлмөр эрхлэгчид
- Газар тариалан эрхлэгчид
- Лангуу түрээслэгчид
- Тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэд
- Бичил уурхай эрхлэгчид
- Чөлөөт уран бүтээлчид
- Гадаад улсад ажиллаж, амьдарч буй иргэд
- Оюутан (18 нас хүрсэн)



Таны төрөл садан, найз нөхдөөс нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах ёстой хүн байна уу, бодоорой. Хэрвээ байгаа бол нийгмийн даатгалд даатгуулахыг зөвлөөрэй. Иргэн "А"-ийн оюутан охин Энхээгийн жишээг хэлж өгөөрэй (Хуудас 12).

Малчин нийгмийн даатгалд сайн дураар даатгуулахдаа эхлээд яах хэрэгтэй вэ?



Малчин Та нийгмийн даатгалд сайн дураар даатгуулахдаа сумынхаа нийгмийн даатгалын байцаагчтай "Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай" гэрээ байгуулна. Гэрээг 2 хувь үйлдэж 1 хувийг гэрээ байгуулсан малчин Та өөрөө, нөгөө хувийг нийгмийн даатгалын хэлтэс (байцаагч) хадгална.

Таны байгуулах гэрээний загварыг энэхүү номын хавсралт хэсгээс хараарай (Хуудас 49, Хавсралт 2).

Сайн дурын даатгалын гэрээг ямар хугацаагаар байгуулах вэ?



- Сайн дурын даатгалд даатгуулах гэрээг 1-12 сарын хугацаагаар байгуулна.
- Гэрээний хугацааг талууд тохиролцон нэг удаа сунгаж болно. Түүний дараа үргэлжлүүлэн даатгуулахдаа дахин шинээр гэрээ байгуулна.

Нийгмийн даатгалын шимтгэл гэж юу вэ?



Нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор даатгуулагч болон ажил олгогчоос хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын санд төлөх урьдчилсан төлбөрийг хэлнэ.



Иргэд нийгмийн даатгалын шимтгэлийг “татвар”-тай андуурах тохиолдол байдаг.

Татвар гэдэг нь хууль тогтоомжийн дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын орлого, эд хөрөнгө, бараа, ажил үйлчилгээнд тодорхой хугацаанд тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж *хариу төлбөргүйгээр* улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгийг хэлдэг. Татвараар цуглуулсан хөрөнгө улс, орон нутгийн төсөвт орж боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах, төрийн байгууллагуудыг ажиллуулах зардалд зориулагддаг.

Харин нийгмийн даатгалын шимтгэлээр бүрдүүлсэн сангийн хөрөнгийг эрх үүссэн даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгоход зарцуулна.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын орлогынхоо хэмжээг хэрхэн сонгох вэ?



Таны нийгмийн даатгалын шимтгэл төлөх нэг сарын орлогын хэмжээ тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ(192 000 төгрөг)-ээс бага байж болохгүй. Харин дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэн дүн(1 920 000 төгрөг)-ээс хэтэрч болохгүй. Энэ нь Та зуун ерэн хоёр мянган төгрөгөөс нэг сая есөн зуун хорин мянган төгрөгийн хооронд шимтгэл төлөх орлогоо сонгоно гэсэн үг.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөр мэдүүлсэн орлогоос сар бүр хэдэн хувийн шимтгэл төлөх вэ?



Та өөрийн мэдүүлсэн сарын хөдөлмөрийн хөлс, орлогоосоо нийгмийн даатгалын шимтгэлийг дор дурдсан хувь хэмжээгээр тооцон гэрээнд заасан хугацаанд нийгмийн даатгалын зохих санд төлнө. Хүснэгт 1-ээс харна уу.

Хүснэгт 1. Нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ

Нийгмийн даатгалын төрөл	Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, орлогоос төлөх шимтгэл (хувиар)
1. Тэтгэврийн даатгал	10.0
2. Тэтгэмжийн даатгал	1.0
3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал (ҮОМШӨ)	1.0
ДҮН	12.0

Сайн дурын даатгалын шимтгэлийг хамгийн доод ба дээд хэмжээгээр төлөхөд сард хэдэн төгрөг болох вэ?



Хамгийн доод хэмжээгээр төлбөл сард **23 040** төгрөг, хамгийн дээд хэмжээгээр төлбөл сард **230 400** төгрөг болно. Хүснэгт 2-оос харна уу.

Хүснэгт 2. Нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ (төгрөгөөр)

Сарын хөдөлмөрийн хөлс, орлого (төгрөг)	Даатгалын төрөл			Сард төлөх шимтгэлийн дүн (төгрөг)
	Тэтгэвэр	Тэтгэмж	ҮОМШӨ	
192 000 (Хамгийн доод хэмжээ)	10% 19 200	1% 1 920	1% 1 920	23 040
1 920 000 (Хамгийн дээд хэмжээ)	10% 192 000	1% 19 200	1% 19 200	230 400



- Сайн дураар даатгуулагчдын дунд “Өө яршиг, хамгийн багаар нь л төлье” гэх хандлага их байдаг. Шимтгэл төлөх орлогоо багаар мэдүүлнэ гэдэг нь нэг талаас Таны төлөх шимтгэлийн хэмжээ бага байх боловч нөгөө талаас эргээд авах тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ ч мөн бага байна гэдгийг анхаараарай. Жишээ нь, өмнө ярилцсан А-ийн охин Энхээ шимтгэл төлөх орлогын доод хэмжээ 192 000 төгрөгөөс шимтгэл төлж байсан тул жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг нь мөн энэ дүнгээс 70 хувиар бодож олгосон байна. Ингэснээр 4 сарын тэтгэмжид нийтдээ 532 528 төгрөг авчээ. Хэрэв Энхээ сар бүр 500 000 төгрөгөөс шимтгэл төлж байсан бол тэтгэмжид 1 386 792 төгрөг авах байв.

- Гэрээнд заасан “шимтгэл төлөх орлогын хэмжээ”-г тухайн гэрээний хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдөхөөс бусад тохиолдолд Та өөрийн дураар өөрчлөх боломжгүй гэдгийг анхаараарай.

Нийгмийн даатгалын шимтгэлийг ямар хугацаанд төлөхөө хэрхэн сонгох вэ?



Та “Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээ” байгуулах үедээ нийгмийн даатгалын шимтгэлээ сар, улирал, хагас жил, жилээр төлөх хувилбаруудаас сонголтоо хийнэ. Та аль хувилбарыг сонгосноос хамаарч нэг удаа төлөх мөнгөн дүн өөр өөр байна. Хүснэгт 3-ыг үзнэ үү.



Хүснэгт 3. Нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацаа, нэг удаа төлөх шимтгэлийн хэмжээ

Шимтгэл төлөх хугацаа (давтамж)	Шимтгэлийн дүн (төгрөгөөр)		Шимтгэл төлөх хугацаа (огноо)*
	Орлогын доод хэмжээ(192 000 төгрөг)-ээс тооцвол	Орлогын дээд хэмжээ(1 920 000)-ээс тооцвол	
Сар бүр	23 040	230 400	Сар бүр гэрээ байгуулсан өдөрт багтаан
Улирал бүр	69 120	691 200	Улирлын эхний сарын гэрээ байгуулсан өдөрт багтаан
Хагас жил тутам	138 240	1 382 400	Хагас жилийн эхний сарын гэрээ байгуулсан өдөрт багтаан
Бүтэн жилээр	276 480	2 764 800	Жилийн аль нэг сард**

Тайлбар: * "Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээ"-ний хавсралтад шимтгэл төлөх он, сар, өдрийг тодорхой тохиролцон тусгана.
 ** Анх гэрээ байгуулах буюу гэрээний хугацааг сунгах үед нэгээс доошгүй сарын шимтгэл төлнө. Үлдсэн шимтгэлийг гэрээний хугацаанд жилийн аль ч сард нэг удаа төлөхөөр тохиролцож болно.



Та нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацаагаа сонгохдоо дараах зүйлсийг харгалзан үзээрэй. Үүнд:

1. Танд болон танай гэр бүлийнхэнд орлого орж ирэх хугацаа, орлогын хэмжээ
2. Танай өрхийн хувьд хамгийн их зарлага гардаг үе (жишээ нь, оюутан хүүхэдтэй бол намар 8, 9 сард гэх мэт)

Мөн та өрхийн аж ахуйнхаа жилийн орлого, зарлагыг тооцож төлөвлөхдөө гэр бүлийн гишүүдийнхээ нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг мөн тооцоорой.

Нийгмийн даатгалын шимтгэлээ хэрхэн төлөх вэ?



- Малчин Та нийгмийн даатгалын хэлтэс(байцаагч)-тэй байгуулсан гэрээнд заасан хугацаанд төлбөл зохих шимтгэлээ өөрийн нэр дээр орлогын мэдүүлэг бичиж, нийгмийн даатгалын харилцах дансанд төлнө. Шимтгэлийг нийгмийн даатгалын байцаагчид бэлэн мөнгөөр төлөхгүй.
- Шимтгэл төлсөн тухай орлогын мэдүүлэг(баримт)-ийг хариуцсан нийгмийн даатгалын байцаагчид авчирч өгч тооцоо нийлэн даатгалын дэвтэрт бичүүлж баталгаажуулна.
- Өөр аймаг, сум, дүүрэгт шилжвэл төлсөн шимтгэлийн тооцоог нийгмийн даатгалын байцаагчтай хийж, гэрээний хугацааг дуусгавар болгон шилжилт хөдөлгөөний тухай тэмдэглэгээг хийлгэнэ.
- Шилжин суурьшсан аймаг, сум, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс(байцаагч)-тэй сайн дурын даатгалд даатгуулсан тухай гэрээг хүсэлт гаргасан сараас эхлэн байгуулж, шимтгэлээ үргэлжлүүлэн төлнө.

ГАНАА НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАВ.



1. Ганаа нийгмийн даатгалд даатгуулахаар ирэв.



2. Нийгмийн даатгалын байцаагч иргэдэд зөвлөгөө өгөв.



3. Ганаа нийгмийн даатгалын байцаагчтай гэрээ байгуулав.



4. Банкинд эхний нэг сарын шимтгэлээ төлж, гэрээгээ баталгаажуулав. Ингэснээр тэр нийгмийн даатгалтай боллоо.

Зураг 4. Нийгмийн даатгалд даатгуулах явц



Нийгмийн даатгалд даатгуулчихлаа, хө. Сард **23 040** төгрөгийн шимтгэл төлж байх юм байна. Улирлын эхний сард төлж байх гэрээ байгууллаа. Чи сумын төв орохдоо Насантай уулзаад даатгуулчихаарай. Өөрөө очихгүй бол болохгүй юм байна, хө.

Өө, тэгээ юу. Болж болж. Жилд нэг хүн **276 480** төгрөг, хоёулаа нийлээд **552 960** төгрөг төлөх нь. Хугацаанд нь төлж байх хэрэгтэй юм байна даа. ...



2.4. Тэтгэврийн даатгал

Тэтгэвэр гэж юу вэ?



Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, тахир дутуу болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсвэл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, түүнчлэн нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.




- Насан байцаагч бид хоёрыг залуу хүмүүс одоо даатгалтай болсон юм чинь цааш нь сайн таниулж байгаарай гэж захьсан. Бас зарим нэг материал өглөө. Эхлээд ахмадууддаа зориулж өндөр насны тэтгэврийн тухай мэдээлэл бэлтгэнэ ээ, хө. Нэг том дэвтэр гаргаж байгаад зураг, мэдээлэл цуглуулж наагаад, эвхдэг үзүүлэн шиг юм хийж авна аа. Энэ их гоё зураг байна, эхний хуудсанд нь наачих.

- Алив, нээрээ л сонин мэдээлэл байна, хө. Пөөх, Японд эрэгтэй, эмэгтэйгүй 65 хүрч байж тэтгэвэрт гардаг юм байна. Чи ер нь энэ багийн сайн дурын ухуулагч болно байгаа ...



Зарим орны иргэдийн тэтгэвэрт гардаг нас




Зураг 5. Тэтгэврийн нас (Эх сурвалж: Дэлхийн нийгмийн хамгааллын тайлан, ОУХБ, 2014/15)



- Япон хүн их урт насалдаг юм гэсэн, эрт тэтгэвэрт гаргачихвал эдийн засаг нь хэцүүдэх юм байгаа биз. Ажил хийж татвар, шимтгэл төлдөг нь цөөн, сул цалин хүртдэг нь олон бол аль ч улс туйлдана шүү дээ. Манай улс ч гэсэн яваандаа тэтгэврийн насыг нэмэх байх. Энэ зургийг наа даа.

Зураг 6. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчид
(тэтгэврийн төрлөөр, хувиар)



Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар, 2015

- Өндөр насны тэтгэвэр авдаг хүн л дийлэнх байдаг юм байна шүү дээ.



- Тийм байна. Одоо тэтгэвэр авч байгаа хүмүүс чинь залуудаа ажил хөдөлмөр эрхэлж, шимтгэл төлөн тэтгэврийн эрхээ олж авсан байгаа. Гэхдээ тэтгэвэр тавих мөнгө нь үндсэндээ одоогийн шимтгэлээс л гарч байгаа гэж байна лээ ...



Ганаа: - Сайн байна уу, Насаан? Ганаа байна. Нэг юм лавлая, хө. Өндөр насны тэтгэвэр тогтоолгоход ажилласан жилийг яаж тооцдог билээ?

Насан: - Тэтгэврийн даатгалд сайн дураар даатгуулж, шимтгэл төлсөн хугацаа нь 1995 оноос өмнө ажилласан хугацаан дээр нэмж тооцогдоно. Жишээ нь: Иргэн "Ц" 1984-1988 он хүртэл ажиллаж байгаад 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс 2015 оны 12 дугаар сарын 1 хүртэл сайн дураар даатгуулсан гэвэл эдгээр хугацааг нэгтгэн тооцож гаргана.



1984-1988 онд ажилласан жил – 5 жил
1995.01.01-2015.12.01-ний хооронд даатгуулж шимтгэл төлсөн хугацаа – 20 жил 11 сар
Нийт шимтгэл төлсөн хугацаа: 25 жил 11 сар (5 жил + 20 жил 11 сар)

Ганаа: - Малчид шимтгэлээ сар, улирал, хагас жил, бүтэн жилээр төлөх боломжтой байгаа нь их зүгээр юм. Ямар тохиолдолд алданги тооцох вэ?

Насан: - Гэрээгээр тохирсон хугацаандаа шимтгэлээ төлөөгүй бол алданги тооцно.

Ганаа: - Өндөр насны бүрэн ба хувь тэнцүүлсэн тэтгэвэр гэж юу байна аа?

Насан: - Өндөр насны бүрэн тэтгэвэр авах эрх дараах болзлыг хангасан даатгуулагчид үүснэ:

Д/д	Хүйс	Нас	Шимтгэл төлсөн хугацаа (жилээр)
1	Эрэгтэй	60	20
2	Эмэгтэй	55	

Хувь тэнцүүлсэн тэтгэвэр авах эрх дараах болзлыг хангасан даатгуулагчид үүснэ:

Д/д	Хүйс	Нас	Шимтгэл төлсөн хугацаа (жилээр)
1	Эрэгтэй	60	10-аас 20 хүртэл жил
2	Эмэгтэй	55	



Даатгуулагч нь тэтгэвэр тогтоолгох нас(эрэгтэй 60 нас, эмэгтэй 55 нас)-д хүрсэн боловч тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-аас доош жил төлсөн бол өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгох эрх үүсэхгүй.



Ганаа: - Аа, шимтгэл төлсөн хугацаагаараа ялгаатай юм байна. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эх 50 нас хүрээд тэтгэвэр тогтоолгож болдог гэсэн. Ямар болзол хангасан байх ёстой вэ?

Насан: Олон хүүхэд төрүүлж өсгөсөн даатгуулагч эх доорх 3 болзлыг нэгэн зэрэг хангаж, нийгмийн даатгалын байцаагчид хүсэлтээ гаргасан нөхцөлд өндөр насны тэтгэврээ тогтоолгоно.

- Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан 4, түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол өсгөсөн;
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-иос доошгүй жил төлсөн;
- 50 нас хүрсэн бол өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэврээ тогтоолгож болно.

Насан: - Ганаа, би чиний олон асуултад хариуллаа. Одоо би чамаас асууя. Даатгуулагч "А" 3 хүүхэд төрүүлсэн, 2 настайд нь үрчлэн авсан 1 хүүхэд нь 12 настай, өөрөө 50 нас хүрсэн, тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жил төлсөн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгож болох уу?

Ганаа: - "А"-ийн 2 настайд нь үрчлэн авч өсгөсөн 1 хүүхдийг нь төрүүлсэн хүүхдийн тоонд оруулан тооцож, хүүхдийн болзлоор өндөр насны тэтгэвэр тогтоож болно.

Насан: - Зөв, сайн байна. Хоёулаа ёстой жинхэнэ зайны сургалт явуулж байх шив дээ. Яасан удаан ярьж байна аа? Болж байгаа юм уу?

- Ганаа:** - Зүгээр, зүгээр. Би сүлжээндээ хязгааргүй ярих эрхтэй байгаа.
- Насан:** - Тэгвэл дахиад хэдэн жишээн дээр ярилцъя. Төрүүлсэн 4 хүүхдийнхээ нэгийг 5 настайд нь бусдад үрчлүүлсэн даатгуулагч эх хүүхдийн болзлоор өндөр насны тэтгэвэр тогтоолгох боломжтой юу?
- Ганаа:** - Нэг хүүхдээ өөрөө 6 настай болтол нь өсгөөгүй 5 настайд нь бусдад үрчлүүлсэн учраас уг эхэд хүүхдийн болзлоор өндөр насны тэтгэврийг тогтоох боломжгүй.
- Насан:** - Жаахан базаахгүй жишээ авъя. Гэхдээ амьдралд байдаг л юм хойно яахав. Төрүүлсэн 4 хүүхдийн нэг нь 8 настайдаа нас барж, 3 хүүхэдтэй үлдсэн эх хүүхдийн болзлоор өндөр насны тэтгэвэр тогтоолгож болох уу?
- Ганаа:** - Хэдийгээр хүүхэд нь нас барсан ч гэсэн уг хүүхдээ 6 настай болтол өсгөсөн учраас болох байх.
- Насан:** - Зөв байна. Болороо та хоёр өндөр насны тэтгэврийн талаар сайн мэдэж аваад ойр хавийнхаа хөгшчүүлд хэлж өгч байхаар шийдсэн чинь их сайн байна. Дахиад асуух юм гарвал асуугаарай.



- Болороо, би өнөөдөр хонио хариулж явахдаа өндөр насны тэтгэвэр тогтоолгох талаар Насантай яриад зөндөө юм шинээр мэдэж авлаа. Одоо цэгцлээд нөгөө дэвтэртээ бичнэ ээ. Тодорхой жишээн дээр яривал их ойлгомжтой байдаг юм байна. Нэг хүснэгт хэрэгтэй санагдлаа.

- Тийм үү? Би бас мэдэж авах юмсан. Булган эгч тэтгэвэрт гарах нас боллоо гэж байна лээ. Тэр бэлэн жишээг л ав л даа...



- Булган эгч ээ, танай Баяраа 6 нас хүрсэн үү?

- Хүрсэн, намар сургуульд орно. Тоглож л суудаг хүн дээ ...

- Тийм үү. Би төрүүлээгүй болохоор 4 хүүхдийн тооно ордогой байх гэж бодож байсан юм.

- Тэгвэл, та хүүхдийн болзлоор тэтгэвэрээ тогтоолгож болох юм байна.



Зураг 7. Ганаа Булгантай ярилцав.



Та өмнөх мэдлэгээ бататгахын тулд өгсөн жишээний дагуух асуултын хариу ба тайлбарыг уншиж, ярилцаарай.

Жишээ	Асуулт	Хариу/тайлбар
Иргэн Булган 50 настай, төрүүлсэн 3 хүүхэд, 6 сартайд нь үрчилж аваад 6 нас хүртэл нь өсгөж байгаа 1 хүүхэдтэй. 1984-1991 онд нэгдэлд малчин, 1992 оноос хойш хувийнхаа малыг маллаж байна. 2000 оноос эхлэн 16 жил тасралтгүй нийгмийн даатгалын шимтгэл төлжээ.	Овог, нэр	Доржийн Булган
	Төрсөн он, сар, өдөр	1966.08.25
	Нийгмийн даатгалын шимтгэл төлж эхэлсэн хугацаа	2000.02.01
	Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нийт хугацаа	24 жил (Тэтгэврийн даатгалд сайн дураар даатгуулж, шимтгэл төлсөн хугацаан дээр 1995 оноос өмнө ажилласан 8 жилийг нэмэв.)
	Тэтгэврийн төрөл	Өндөр насны бүрэн тэтгэвэр
	Тэтгэвэр тогтоолгох хөнгөлөлттэй нөхцөл	Олон хүүхэд төрүүлж өсгөсөн.

Хөдөө аж ахуйн нэгдэлд ажилласан хугацааг хэрхэн тооцох вэ?



1968 он хүртэлх хугацаанд: Тухайн жилд нэгдлийн гишүүн малчин эмэгтэй 110 хоног, эрэгтэй нь 150 хоног ажилласан бол нэг жил ажилласнаар тооцно.

1968 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 1991 он хүртэлх хугацаанд: Тухайн жилд нэгдлийн эрэгтэй, эмэгтэй малчин гишүүд 250 буюу түүнээс дээш хоног ажилласан бол 12 сар буюу нэг жил ажилласнаар тооцно. Харин дээрх хугацаанд ажилласан хоногийн тоо 110, 150, 250-иас бага байвал 30-д хувааж, тухайн жилд ажилласан хугацааг сараар тооцно.

1991 оноос хойш: Хөдөө аж ахуйн нэгдлийн суурин дээр өөрчлөн байгуулагдсан компанид малчнаар ажилласан бол ажилласан хугацааг улсын байгууллагад ажиллагчдынхтай адил тооцно.

Нийгмийн даатгалын шимтгэл төлсөнд тооцогдох бусад хугацааны талаарх мэдээллийг нийгмийн даатгалын байцаагчаасаа аварай.



2015 оны 12 дугаар сард Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд "Малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нэг жилийг нэг жил хоёр сараар шимтгэл төлсөн хугацаанд тооцно" гэж заасан байна. Энэ хууль 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлнэ.



Ганаа сумын төв орох бүртээ нийгмийн даатгалын байцаагч Насантай уулзаж ярилцдаг болов.

Ганаа: - Хууль, журмыг мэдэж байж л эрхээ бүрэн эдлэх юм байна, хө.

Насан: - Тэгэлгүй яахав. Чи өвгөнийхөө ажилд их тус болж байна шүү. Болороо та хоёр боловсролтой залуу хүмүүс болохоор малчдад их нөлөөтэй байна. Байнга ухуулж ойлгуулж байх шаардлагатай хүмүүс их бий шүү. Би ойр ойрхон тэдэнтэй уулзаж чадахгүй шүү дээ.

Ганаа: - Одоо намайг гэгээрүүлэх юу байна, хө?

Насан: - Энэ удаад өндөр насны тэтгэврийн хугацааны талаарх мэдээллийг уншаад, бодолтуудтай танилц.

Өндөр насны тэтгэвэр олгох хугацаа. Өндөр насны тэтгэврийг даатгуулагч өргөдлөө тэтгэвэр тогтоолгох насанд хүрэхээс өмнө гаргасан бол уг насанд хүрсэн өдрөөс, хэрэв тэтгэвэр тогтоолгох насанд хүрснээс хойш гаргасан бол өргөдлийг нийгмийн даатгалын байцаагч хүлээн авсан өдрөөс эхлэн, нас барсны дараагийн сар дуустал олгоно.

Жишээ 1: Даатгуулагч "Б" 2015 оны 2 дугаар сарын 1-нд 60 нас хүрсэн, тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жил төлсөн, тэтгэвэр тооцох сарын дундаж хөдөлмөрийн хөлс нь 450 000 төгрөг, 2015 оны 1 дүгээр сарын 27-нд тэтгэвэрт гарах хүсэлтээ нийгмийн даатгалын байцаагчид гаргасан гэвэл өндөр насны тэтгэврийг хэрхэн тогтоохыг бодъё.

Нийгмийн даатгалын байцаагч нь даатгуулагч "Б"-д өндөр насны тэтгэвэр тогтоох эрх үүсэх эсэхийг нягтална. Дээрх жишээнээс харахад даатгуулагч "Б" нь:

- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жил төлсөн,
- 60 насанд хүрсэн,
- Тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан тул өндөр насны бүрэн тэтгэвэр тогтооно.

20 жил шимтгэл төлсөн тул тэтгэвэр бодох хувь - 45%

Тэтгэвэр тооцох сарын хөдөлмөрийн хөлс, орлого – 450 000 төгрөг

Үүнээс сард олгох тэтгэврийг бодвол:

$$450\,000 \text{ төгрөг} \times 45\% = 202\,500 \text{ төгрөг}$$

Даатгуулагчийн тэтгэвэр Засгийн газраас тогтоосон тэтгэврийн доод хэмжээнээс бага байж болохгүй тул "Б"-д 202 500 төгрөг бус 230 000 төгрөгийн тэтгэврийг 2015 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс тооцож олгоно.



Өндөр насны бүрэн тэтгэврийн доод хэмжээ нь тухайн үед мөрдөгдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ нь мөн хөлсний 50 хувиас багагүй байна (*Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг*).

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 52 дугаар тогтоолоор бүрэн тэтгэврийн доод хэмжээг 230 000 төгрөгөөр, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 195 000 төгрөгөөр тогтоосон байна.

Ганаа: Даатгуулагчдыг хэт бага тэтгэвэр авахаас сэргийлсэн чухал зохицуулалт байна шүү. Өөрийнх нь тэтгэврийг бодоход 202 500 төгрөг гарсан ч нэмж 27 500 төгрөг өгөх юм байна, тийм үү?

Насан: Тиймээ. Чи яг зөв бодсон байна. Энэ зөрүүг тэтгэврийн даатгалын сангаас төлж байгаа юм.

Ганаа: Булган эгчид ирэх 8 сарын эхээр төрсөн өдрөөсөө өмнө эртхэн баримт бичгээ бүрдүүлж, өндөр насны тэтгэвэр тогтоолгох өргөдлөө өгөх хэрэгтэй гэж хэлье. Тэгвэл хугацаа алдахгүй төрсөн өдрөөс нь эхлэн тооцож тэтгэвэр нь олгогдох юм байна.

Жишээ 2: Даатгуулагч “Э” тэтгэврийн даатгалын шимтгэлийг 30 жил 11 сар төлсөн, тэтгэвэр тооцох сарын хөдөлмөрийн хөлс, орлого нь 425 000 төгрөг бол түүний тэтгэврийн хэмжээг тооцож үзье.



Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд зааснаар 20 жилээс дээш хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн жил тутамд 1.5 хувиар, сар тутамд 0.125 хувиар өндөр насны тэтгэвэр тогтоолгосон хөдөлмөрийн хөлснөөс тооцож нэмэгдэл олгоно.

Тэгэхээр “Э”-ийн хувьд:

- 20 жил шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэвэр:
191 250 төгрөг (425 000 х 45%)
- 20 жилээс дээш шимтгэл төлсөн хугацаа:
10 жил 11 сар (30 жил 11 сар - 20 жил)
- Шимтгэл төлсөн 10 жил 11 сард ногдох тэтгэвэр:
15 хувь (10 жил х 1.5%)
63 750 төгрөг (425 000 х 15%)
1.375 хувь (11 сар х 0.125%)
5 844 төгрөг (425 000 х 1.375%)
- Сард олгох өндөр насны тэтгэвэр:
260 844 төгрөг (191 250 төгрөг + 63 750 төгрөг + 5 844 төгрөг)



- Шимтгэл төлж байгаа орлогын хэмжээ өндөр байхаас гадна шимтгэл төлсөн хугацаа урт байх тусам авах тэтгэврийн хэмжээ өндөр байдаг юм байна. Шимтгэлээ тогтмол, тасралтгүй төлөх нь чухал юм байна шүү.

- Тийм байна. Дулмаа эмээ ажил хөдөлмөр хийж, орлоготой байх үедээ нийгмийн даатгалын шимтгэлээ төлж баймаар юм гээд байсан үнэн хэлжээ. Дулмаа гуай ядаж 20 жил шимтгэл төлсөн бол доод хэмжээний тэтгэвэр 230 000 төгрөг сар бүр авах байж.



- Үгүй ядахнаа 10 жил шимтгэл төлсөн бол гээч. Тэгвэл хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгоод сар бүр 195 000 төгрөг авна шүү дээ.

Даатгуулагч



Даатгуулагч сумын нийгмийн даатгалын байцаагчид тэтгэвэр тогтоолгох тухай өргөдөл гаргана. Дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

- иргэний үнэмлэхийн хуулбар, 3x4 хэмжээтэй цээж зураг
- нийгмийн даатгалын болон хөдөлмөрийн дэвтэр
- 1995 оноос өмнө ажилласан хугацаанд авсан хөдөлмөрийн хөлс, орлогоос тэтгэвэр тогтоолгохыг хүсвэл байгууллагын цалин хөлсний тодорхойлолт, эсвэл архивын лавлагаа
- хүүхдийн болзлоор тэтгэвэр тогтоолгох бол хүүхдүүдийн гэрчилгээний хуулбар

Нийгмийн даатгалын байгууллага



Нийгмийн даатгалын байгууллага тэтгэвэр тогтоох асуудлыг 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

Банк



Тэтгэврийг банкаар дамжуулан олгоно. Даатгуулагч тэтгэврийн насанд хүрэхээс өмнө өргөдөл гаргасан бол уг насанд хүрсэн өдрөөс, тэтгэврийн насанд хүрснээс хойш гаргасан бол өргөдлийг хүлээн авсан өдрөөс эхлэн нас барсны дараагийн сар дуустал олгоно.

Зураг 8. Өндөр насны тэтгэвэр тогтоож олгох явц



1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойш төрсөн даатгуулагчид "Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс" нээнэ. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэврийг даатгуулагчийн төлсөн шимтгэлийн хэмжээ, тэтгэвэр авах дундаж хугацаатай уялдуулсан аргаар тооцохоор зохицуулсан байна. Гэхдээ 1960 оны 1 дүгээр сарын 1-нээс 1979 оны 1 дүгээр сарын 1-ний хооронд төрсөн даатгуулагч өмнө жишээ авч тайлбарласан аргачлалаар тэтгэврээ тогтоолгох боломжтой.



- Доод голын Цэрэн ах бас тэтгэвэр аваад байдаг биздээ. Хөл муутай л болохоос нас нь бол залуу даа ...

- Чи эндээс хардаа. Өндөр насны тэтгэвэрээс гадна тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны гээд хоёр өөр төрлийн тэтгэвэр олгодог юм байна.



Тахир дутуугийн тэтгэвэр

Ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас доошгүй хувиар байнга буюу удаан хугацаагаар алдсан даатгуулагч:

- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20-иос доошгүй жил төлсөн;
- Эсвэл, тахир дутуу болохын өмнөх 5 жилийн 3 жилд нь шимтгэл төлсөн бол тахир дутуугийн тэтгэвэр авах эрхтэй.



Тэжээгчээ алдсаны тэтгэвэр

Ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барсан даатгуулагч:

- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20-иос доошгүй жил төлсөн;
- Эсвэл, нас барахын өмнөх 5 жилийн 3 жилд нь шимтгэл төлсөн бол түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрхтэй.



- Аан, Цэрэн ах тэгвэл тахир дутуугийн тэтгэвэр авдаг юм байна. Нээрээ л хүний амьдралд юу ч тохиолдоо билээ. Хүн бүр эрүүл саруул өтлөх баталгаа байхгүй юмдаа. "5 жилийн 3 жилд нь шимтгэл төлсөн байвал" гэдэг чинь залуухан даатгуулагч хөдөлмөрийн чадвараа алдвал тэтгэвэр тогтоолгох боломж олгодог юм байна. Эдгэрч эрүүл болтлоо тогтмол тэтгэвэр авна гэдэг мэдээж маш чухал.

- Хөдөлмөрийн чадвар нь нөхөн сэргээгдэхгүй бол тахир дутуугийн тэтгэврийг өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүртэл тийм урт хугацаагаар олгодог гэхээр нийгмийн даатгал аргагүй л чухал байгаа биз. Цэрэн ах хэрэв даатгуулаагүй байсан бол юун сар бүр тэтгэвэр авах, өөрт нь ч, гэрийнхэнд нь ч хэцүү байх байсан даа.



Даатгуулагч



Нийгмийн даатгалын байгууллага



Банк



Даатгуулагч тэтгэвэр тогтоолгох тухай өргөдлөө тахир дутуу болсноос хойш 14 хоногийн, хэрэв хүндэтгэх шалтгаантай байсан бол 3 сарын дотор гаргана.

Бүрдүүлэх материал:

- иргэний үнэмлэхийн хуулбар, 3x4 хэмжээтэй цээж зураг
- нийгмийн даатгалын болон хөдөлмөрийн дэвтэр
- 1995 оноос өмнө ажилласан хугацаанд авсан хөдөлмөрийн хөлс, орлогоос тэтгэвэр тогтоолгохыг хүсвэл байгууллагын цалин хөлсний тодорхойлолт, эсвэл архивын лавлагаа
- цэргийн батлах, эсвэл цэргийн архивын лавлагаа
- даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын тухай Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр

Нийгмийн даатгалын байгууллага тэтгэвэр тогтоох асуудлыг 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

Даатгуулагч хөдөлмөрийн чадвараа бүрэн (70 буюу түүнээс дээш хувиар) алдсан бол тэтгэврийг өндөр насны тэтгэвэр тооцохтой адил аргаар бодно.

Харин хөдөлмөрийн чадвараа хагас (50-иас 70 хүртэл хувиар) алдсан даатгуулагчийн тахир дутуугийн бүрэн тэтгэврийн хэмжээг тооцохдоо 20 жил шимтгэл төлсөн бол тэтгэвэр тогтоолгох сарын дундаж хөдөлмөрийн хөлсний 45 хувиас хөдөлмөрийн чадвар алдалтын хувиар бодно.

Өндөр насны тэтгэврийнхтэй адил 20-иос дээш жил шимтгэл төлсөн хугацаанд нэмэгдэл тооцож олгоно. Тахир дутуугийн тэтгэврийн доод хэмжээ нь өндөр насны тэтгэврийн доод хэмжээтэй адил байна.

Тэтгэврийг банкаар дамжуулан олгоно.

Тахир дутуугийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүртэл, хэрэв тэтгэвэр авагч нас барвал нас барсны дараагийн сар дуустал олгоно.

Зураг 9. Тахир дутуугийн тэтгэвэр тогтоож олгох явц



- Цэрэн ах ч лав 20-иос дээш жил шимтгэл төлж ажиллаж чадаагүй байх аа. Тэгэхээр тэтгэвэр дээр нь нэмэгдэл байхгүй гэсэн үг. Хэдийг авдаг юм бол?

- "Тахир дутуугийн тэтгэврийн доод хэмжээ нь өндөр насны тэтгэврийн доод хэмжээтэй адил байна" гэсэн байна. Өндөр насны бүрэн тэтгэврийн доод хэмжээ нь 230 000 төгрөг, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ нь 195 000 төгрөг шүү дээ. Тэгэхээр үүнээс л багагүй байж таараа.



Даатгуулагчийн гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд



Нийгмийн даатгалын байгууллага



Банк



Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд даатгуулагчийг нас барснаас хойш 14 хоногийн, хэрэв хүндэтгэх шалтгаантай байсан бол 3 сарын дотор өргөдлөө гаргана.

Бүрдүүлэх материал:

Бидний өмнө танилцсан тэтгэвэр тогтоолгоход шаардлагатай баримт бичиг дээр дараах 2 зүйл нэмэгдэнэ. Үүнд:

- тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн төрсний гэрчилгээ, ам бүлийн тодорхойлолт
- даатгуулагчийн нас барсан тухай гэрчилгээний хуулбар

Нийгмийн даатгалын байгууллага тэтгэвэр тогтоох асуудлыг 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

Тэжээгчээ алдсаны бүрэн тэтгэврийг тооцохдоо:

- Нас барсан даатгуулагчийн дундаж хөдөлмөрийн хөлснөөс өндөр насны бүрэн тэтгэвэр бодох хувь хэмжээнд ногдох хэсгийг олно.
- Түүнээс 3-аас дээш тэжээлгэгчтэй бол 100 хувиар, 2 бол 75 хувиар, 1 бол 50 хувиар бодно.

Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх бүхий хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн жагсаалтыг Хавсралт 2-оос үзнэ үү.

Тэтгэврийг банкаар дамжуулан олгоно.

Тэжээгчээ алдсаны тэтгэврийг тэжээгч нь нас барсан өдрөөс эхлэн хүүхдэд 19 нас хүртэл, тахир дутуу иргэнд хөдөлмөрийн чадвараа алдсан хугацаанд нь, тэтгэврийн насанд хүрсэн иргэнд нас барсны дараагийн сар дуустал олгоно.

Зураг 10. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоож олгох явц



- Саяхан мэдээгээр нийгмийн даатгалын мөнгөө өвлүүлдэг болох хэрэгтэй гээд л яриад байсан санагдахын ... Тэжээгчээ алдсаны тэтгэвэр чинь үр хүүхэд, гэр бүлийнхэнд нь үлдэж байгаа нэг хэлбэр юм биш үү. Хүүхдүүд нь насанд хүртлээ энэ тэтгэврийг авах юм байна.



Өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоох талаар бид өмнө ярилцсаныг санаарай. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 3-аас доошгүй жил төлсөн даатгуулагч шимтгэл төлсөн хугацаандаа ногдох тахир дутуугийн тэтгэврийг, харин нийтдээ 5-аас доошгүй жил, үүнээс нэг жил нь тасралтгүй төлсөн даатгуулагч нас барвал түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэжээгчээ алдсаны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй. Энэ талаарх нэмэлт мэдээллийг нийгмийн даатгалын байцаагчаасаа аваарай.

Дараах зургийг ажиглаад, асуултад хариулаарай.

- Тэтгэвэр, тэтгэмж хоёр ямар ялгаатай вэ?
- Нийгмийн даатгалын сангаас ямар тэтгэвэр олгодог вэ?
- Нийгмийн даатгалын сангаас ямар тэтгэмж олгодог вэ?
- Малчинд ажилгүйдлийн тэтгэмж олгох уу? Үгүй буюу тийм бол, яагаад?
- Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчид ямар төрлийн даатгалд хэдэн хувийн шимтгэл төлдөг вэ?
- Тэтгэврийн даатгалын шимтгэл яагаад хамгийн их байдаг гэж та бодож байна вэ?



Зураг 11. Тэтгэвэр, тэтгэмж



- Тэтгэвэр нь харьцангуй урт хугацаанд сар бүр олгогддог юм биш үү?

- Тийм байна. Хүн тэтгэвэрт гараад хичээн ч жил тэтгэвэр авах юм билээ. Шимтгэл нь даатгалын бусад төрлөөс их байхаас аргагүй юм байна, хө.





- 55, 60 нас хүрч тэтгэвэр тогтоолготол хаа ч байсан юм гэж боддог залуучууд олон бий. Гэтэл амьдралд богино хугацаатай боловч дахин давтан тохиолддог эрсдэлийн үед мөнгөн тэтгэмж олгож, орлоготой байх боломж бүрдүүлдэг гэдгийг бид тэр бүр мэдэхгүй л явж шүү дээ. Сайн дурын даатгалд эрт хамрагдсан бол хоёр хүүхдээ гаргахад тэтгэмж авах л байж.

- Харин тиймээ. Одоо хоёулаа ямар ч байсан шимтгэлээ тасралтгүй төлнө өө. Тэтгэмжийн даатгалаас олгодог гурван төрлийн тэтгэмжтэй холбоотой энэ хэсэг мэдээллийг сайн уншмаар юм байна.



Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг авахын тулд даатгуулагч ямар болзол хангасан байх ёстой вэ?



- Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг жирэмсний чөлөө авахаас өмнө 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сар нь тасралтгүй төлсөн байна.
- Даатгуулагч эх хүүхдээ 196 хоног тээгээд дутуу төрүүлсэн болон үр хөндүүлсэн, жирэмслэлтийг эмнэлгийн аргаар тасалсан, мөн 196 хоног тээгээгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн бол тэтгэмж авна.

Сайн дураар даатгуулагч эхийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг хэдэн хувиар бодож олгодог вэ?



Шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, орлогын дунджаас 70 хувиар тооцон 4 сарын хугацаанд олгоно.

Эмнэлгийн байгууллага даатгуулагч эхэд жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг:

- Жирэмсний амралт эхэлснээс хойш 30 хоногийн дотор;
- Амаржсаны дараа 30 хоногийн дотор бичиж олгоно.

Эмнэлгийн хуудас, нийгмийн даатгалын дэвтрээ оршин суугаа аймаг, сум, дүүргийнхээ нийгмийн даатгалын хэлтсийн байцаагчид авчирч өгч шимтгэл төлсөн хугацааг тодорхойлон бичүүлж, тэтгэмжээ бодуулна.

Жишээ: Сайн дураар даатгуулагч эх "А" нь тэтгэмжийн даатгалын шимтгэлийг 3 жил төлсөн, тэтгэмж бодох хөдөлмөрийн хөлсний дундаж 400 000 төгрөг, 2015 оны 5 дугаар сарын 1-нээс жирэмсний эмнэлгийн хуудсаа бичүүлсэн бол тэтгэмжийг дараах байдлаар бодно. Үүнд:

- Сарын дундаж орлого – 400 000 төгрөг
- Сарын ажлын өдрийн дундаж хоног – 21.2 хоног
- Нэг өдөрт ногдох орлого
18 868 төгрөг (400 000 төгрөг : 21.2 хоног)
- Нэг өдөрт ногдох тэтгэмж:
13 207 төгрөг (18 868 төгрөг x 70%)
- Тэтгэмж олгох хоног (ажлын өдрөөр) - 42 өдөр
- Даатгуулагчид олгох жирэмсний тэтгэмж:
554 717 төгрөг (13 207 төгрөг x 42 өдөр)

Амаржсаны тэтгэмжийг эмнэлгийн хуудсыг үндэслэн мөн ижил аргаар тооцох бөгөөд даатгуулагч "А" жирэмсний болон амаржсаны тэтгэмжид нийтдээ 1 109 434 төгрөг авна.



Сайн дурын даатгуулагч эхийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг ажлын өдрөөр тооцож олгоно.



Даатгуулагч ямар нөхцөлд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй вэ?



- Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдахаас өмнө 3, түүнээс дээш сарын хугацаагаар төлсөн даатгуулагч авна.
- Даатгуулагч эх хүүхдээ 196 хоног хүртэл тээгээгүй дутуу төрүүлсэн буюу үр хөндүүлсэн бол мөн уг тэтгэмжийг авна.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хэдэн хувиар бодож олгодог вэ?



Шимтгэл төлсөн хугацаа	Тэтгэмж бодох хувь
5 хүртэл жил	50
5-14 жил	55
15, түүнээс дээш жил	75

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ямар хугацаанд олгодог вэ?



Даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдахад нэг удаад ажлын 66 өдрийн хугацаанд, харин хорт хавдар болон сүрьеэгээр анх өвчлөхөд ажлын 132 өдрийн хугацаанд тэтгэмж олгож болно. Хуанлийн нэг жилд удаа дараа өвчилсөн тохиолдолд нийтдээ ажлын 132 өдрөөс илүүгүй хугацаанд тэтгэмж олгоно.



- Энэ тэтгэмжийг бас жирэмсний болон амаржсаны тэтгэмж шиг эмнэлгийн хуудсаа байцаагчдаа аваачиж өгөөд тооцуулдаг юм байна. Бид чинь одоо тэтгэмжийн даатгалд 1 хувийн л шимтгэл төлж байгаа. Сард 1 920 төгрөг. Тэгэхээр 3 сард 5 760 төгрөгийн шимтгэл төлөөд л хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй болно гэсэн үг юм байна. Базарыг эртээд эмнэлэгт хэвтэхэд 60 000 төгрөг авлаа гээд Нансалмаа ярьж байсан шүү дээ. Тэр хоёр ч нийгмийн даатгалын ач холбогдлыг эртнээс мэдсэн хүмүүс байна даа.

Оршуулгын тэтгэмж авах эрх ямар нөхцөлд үүсэх вэ?



- Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг нийтдээ 36 сараас доошгүй хугацаагаар төлсөн даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барвал энэ тэтгэмжийг авна.
- Даатгуулагч ҮОМШӨ-ний улмаас нас барсан бол оршуулгын тэтгэмжийг шимтгэл төлсөн хугацаа харгалзахгүйгээр олгоно.
- Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч нас барвал тэтгэмж авах эрх үүснэ.



- "Бурхан болооч"-ийг нутаглуулахад хүртэл тэтгэмж өгдөг юм байна. Юмны нарийн учрыг мэдэхгүй байна гэдэг ч хэцүү юмдаа. Насан байцаагч манай хөдөөнийхөн нийгмийн даатгалын ашиг тусыг ойлгоогүйгээс даатгуулахгүй байна гээд байдаг, үнэн юмаа.

- Чи бид хоёр ч гэсэн бэлтгэсэн мэдээллээ улам баяжуулаад чадах чинээгээрээ хавь ойрынхоо хүмүүст хэлж ойлгуулах хэрэгтэй юм байна. Аль болох олон хүн даатгуулбал сан нь ч арвижна, өвчин зовлон тохиолдсон үедээ орлоготой үлдэх хүмүүс ч нэмэгдэнэ биз дээ. Харин Насангаас сайн асууж, зөв мэдээлэл хүргэх юм шүү.



- Тийм шүү. Овоо л мэдээлэлтэй болж байна. Гэхдээ асууж тодруулах юм бас байна аа, хө. ҮОМШӨ-ний даатгалаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх ямар тохиолдолд үүсэх үү, үйлдвэрлэлийн осол гэж юуг хэлэх үү, малчин хүн малаа маллаж яваад бэртэж гэмтэн хөдөлмөрийн чадвараа түр болон байнга алдвал тэтгэвэр, тэтгэмж авах уу гээд Насангаас асуух юм байна.

2.6. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал

Даатгуулагч хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөж эрүүл мэндээр хохирох, амь насаа алдахыг *үйлдвэрлэлийн осол* гэнэ.

Даатгуулагчийн хөдөлмөрлөх явцад үүссэн үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалсан өвчнийг *мэргэжлээс шалтгаалсан өвчин* гэнэ.



Ганаа: - ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийг малчид төлөх хэрэгтэй юу? Малчид үйлдвэрлэлийн осолд өртөхгүй биз дээ?

Насан: - Яалаа гэж дээ Ганаа. Жишээ нь, малаа хариулж яваад мориноосоо унаад бэртэх тохиолдол гардаг. Энэ тохиолдолд хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад эрүүл мэндээр хохирсон гэж үзэн даатгалын энэ сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, хэрэв бүр их хүнд бэртэл авч хөдөлмөрийн чадвараа байнга алдвал тахир дутуугийн тэтгэвэр ч олгоно.

Ганаа: - Бид нар чинь хээр гадаа явж малаа хариулдаг хүмүүс, хээр гадаа бэртлээ гэхэд үйлдвэрлэлийн осолд өртсөнийг хэн тогтоох болж байна?

Насан: - Үйлдвэрлэлийн ослыг сумын Засаг даргын захирамжаар байгуулсан комисс судлан тогтоодог. Манай суманд ч бас байгуулагдсан байгаа. Тиймээс даатгуулагч осолд орсон тухайгаа мэдэгдэх ёстой. Комисс үйлдвэрлэлийн осол мөн байна гэж тогтоовол даатгуулагч тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох өргөдөл гаргахдаа үйлдвэрлэлийн ослын актаа бусад баримт бичгийн хамт өгнө.

Ганаа: - Түрүүн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, тахир дутуугийн тэтгэвэр олгодог гэсэн үү?

Насан: - Тиймээ. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр ч бас олгоно. Гэхдээ энэ сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж нь өмнө чи бид хоёрын ярилцсан тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалынхаас хэд хэдэн зүйлээр ялгаатай. Даатгуулсан л бол хэдий хугацаанд шимтгэл төлснийг харгалзахгүй. Жишээ нь, өнөөдөр даатгалд хамрагдаж сайн дурын даатгалын гэрээгээ байгуулсан хүн маргааш үйлдвэрлэлийн осолд орвол тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсэх боломжтой гэсэн үг.

Мөн авах тэтгэвэр, тэтгэмж нь ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвар алдсан үед олгох тэтгэвэр, тэтгэмжтэй харьцуулахад өндөр байна. Тэтгэмжийн даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хамгийн дээд тал нь 75 хувиар бодож олгодог бол ҮОМШӨ-ний даатгалын сангаас 100 хувиар бодож олгодог.



Өмнө тайлбарласан тэтгэвэр, тэтгэмжээс гадна ҮОМШӨ-ний даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед) хийлгэх, рашаан, мэргэжлээс шалтгаалсан өвчний сувилалд сувилуулахад унааны зардал, сувиллын хувьсах зардал, тэтгэврийн даатгалын шимтгэлийн зардал олгоно.



ДҮГНЭЛТ:

- Нийгмийн даатгал, түүний ач холбогдол
- Нийгмийн даатгалын төрөл ба сан
- Сайн дурын даатгал
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардлын талаар тодорхой мэдээлэл авч, дасгал ажиллалаа.



Одоо мэдлэгээ бататган цэгцлэх дасгал ажиллаарай. Суралцагч Та эхлээд Ганаа, Болороо хоёрын жишээгээр нэг дэвтэр гаргаад, гарын авлагынхаа өмнөх хэсэгт буй зургууд(1-11), шаардлагатай хүснэгт, жишээ, бодолтыг хувиан наагаарай.

Чиглүүлэг:

- Хэрэгцээтэй зураг, хүснэгт, жишээг сумын төв орохдоо хувилуулж аваарай.
- Та нийгмийн даатгалын тухай зурагт ном өөрийнхөө гараар бүтээгээд, түүнийгээ ашиглан хэн нэгэнд ярьж өгөөрэй.
- Номоо бүтээх, хүнд ярьж өгөх явцад эргэлзээтэй зүйл гарвал нийгмийн даатгалын байцаагчаасаа лавлаарай.
- Сурсан зүйлээ сайн санахгүй байгаа үед бүтээсэн номоо эргэн харж байгаарай.
- Хэвлэл, радио, телевизээс олж авсан мэдээлэл, амьдралын жишээгээр номоо байнга баяжуулж байгаарай.




Дараах бүдүүвчийн эхний хэсгээс санаа аван гүйцээж бичээрэй.

Чиглүүлэг:

- Шаардлагатай үед энэ номоо эргэж хараарай (Хуудас 9-11).
- Таны бичиж байгаа зүйл бүдүүвчид багтахгүй бол өөрөө эргээд ойлгохоор товчилж бичээрэй. Шаардлагатай гэж үзвэл бүдүүвчийг дэвтэртээ наагаарай.

Нийгмийн даатгалын төрөл ба сан





Дараах хүснэгтэд буй жишээг уншаад, асуултын хариу ба тайлбарыг бичээрэй. Чиглүүлэг:

- Энэхүү гарын авлагын 24 дүгээр хуудасны тэтгэвэр бодох аргачлалыг шаардлагатай бол эргэж хараарай.
- Даатгуулагч Дулмаагийн 20-иос дээш жил шимтгэл төлсөн жил бүрийг 1.5 хувиар тооцож нэмэхээ мартуузай ($15 \times 1.5\% = 22.5$)

Жишээ	Асуулт	Хариу/тайлбар
Даатгуулагч Т. Дулмаа 2016 оны 3 дугаар сарын 15-нд 55 нас хүрсэн, 35 жил ажиллаж шимтгэл төлсөн, 2016 оны 3 дугаар сарын 30-нд нийгмийн даатгалын байцаагчид тэтгэвэрт гарах хүсэлтээ гаргасан, сарын дундаж хөдөлмөрийн хөлс 400 000 төгрөг.	Овог, нэр	
	Төрсөн он, сар, өдөр	
	Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нийт хугацаа	
	Тэтгэврийн төрөл	
	Тэтгэвэр тогтоолгох болзол	
	Бүрдүүлэх материал	
	Бодолт	
	Тэтгэврийн хэмжээ (төгрөг)	
	Тэтгэвэр авч эхлэх он, сар, өдөр	



Суралцагч та энэхүү бүлгийг үзээд, ямар амжилтад хүрсэн талаар “Амжилтын түүх”-ээ бичээрэй.

“Амжилтын түүх” бичих загвар

Суралцсан хугацаа: _____

Хэрхэн суралцсан бэ? _____

Чухал өөрчлөлт юу байсан бэ? _____

Яагаад түүнийг чухал гэж үзэж байна вэ? _____

Ирээдүйд гарах өөрчлөлт? _____

“Нийгмийн даатгал” сэдвийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадвар, өөртөө болон гэр бүлдээ гарч буй өөрчлөлт дэвшлийг үнэлнэ үү.

Зөвшөөрч буй хариуны харгалзах нүдийг будаарай. Жишээг харна уу.

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1. Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа болон шимтгэл тооцсон орлогын хэмжээ авах тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээнд нөлөөлнө.			
2. Малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нэг жилийг нэг жил хоёр сараар шимтгэл төлсөн хугацаанд тооцно.			
3. Нийгмийн даатгал 4 төрөлтэй, төрөл тус бүр нь бие даасан мөнгөн хөрөнгийн сантай байна.			
4. 20 жилээс дээш хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн жил тутамд 1.5 хувиар, сар тутамд 0.125 хувиар өндөр насны тэтгэвэр тогтоолгосон хөдөлмөрийн хөлснөөс тооцож нэмэгдэл олгоно.			
5. 50 нас хүрсэн эмэгтэй 4 хүүхэдтэй боловч заримыг нь үрчилж авч өсгөсөн бол хүүхдийн болзлоор өндөр насны тэтгэвэр тогтоолгож болохгүй.			
6. Хөдөө аж ахуйн нэгдэлд ажиллаж байсан хугацааг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн жил дээр нэмж тооцдог.			
7. Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг жирэмсний чөлөө авахаас өмнө 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн даатгуулагч жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй.			
8. Сайн дураар даатгуулсан эхийн шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, орлогын дунджаас 50 хувиар тооцон 4 сарын хугацаанд жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгоно.			
9. Тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгох бол даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын тухай Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр шаардлагатай.			
10. Би нийгмийн даатгалын ач холбогдлыг сайн ойлгож, сайн дураар даатгуулсан.			
11. Би нийгмийн даатгалд өмнө нь даатгуулсан байсан. Шимтгэлээ хугацаанд нь төлж байгаа.			

ТАЙЛБАР: Та дээрх хүснэгтэд сонгож будсан хариугаа шалгахдаа энэ номын ард хавсаргасан хариутай тулгаж үзээрэй (Хуудас 54, Хавсралт 4.3-а, Хүснэгт 1).

ҮНЭЛГЭЭ:

Бүх хариу таарч байвал	Хангалттай сайн
2-3 зөрж байвал	Хангалттай
3-аас дээш зөрж байвал	Сэдвээ дахин үзнэ үү.

ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

Зорилго: Энэхүү сэдвийг судлах явцад Та:

- Эрүүл мэндийн даатгал, түүний ач холбогдол
- Малчид эрүүл мэндийн даатгалд хамрагдах арга зам (журам)
- Малчны төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээ, төлөх хугацаа
- Эрүүл мэндийн даатгалд хамаарах эмчилгээ, үйлчилгээ
- Эрүүл мэндийн даатгалаас хариуцах төлбөр, эрүүл мэндийн даатгалын байгууллага, даатгуулагч хоёр хамтарч төлөх хамтын төлбөрийн талаарх мэдлэгээ нэмэгдүүлнэ.
- Мэдлэгээ хэрэглэх дасгал, даалгавар гүйцэтгэнэ. Сурсан зүйлээ өөрөө үнэлнэ.



3.1. Эрүүл мэндийн даатгал, түүний ач холбогдол

Бат:

- Хангай чи бид нарт эрүүл мэндийн даатгалын ач тусыг сайн ойлгуулаад өгөөч.

Хангай:

- Бидний жилд төлж байгаа 46 080 төгрөг өвдсөн үед маань эмчлүүлэх зардал, эмийн үнийн хөнгөлөлт болж ирнэ. Нэг хүн жилд 2 сая хүртэл төгрөгийн эмчилгээ, үйлчилгээ авч болдог юм билээ.

Бат:

- Ямар үйлчилгээ авч болохын?

Хангай:

- Эмчид үзүүлэх, шинжилгээ өгөх, эмнэлэгт хэвтэх, эм авах гээд олон юм бий.

Булган:

- Нэг гэр бүлийнхэн ашиглаагүй даатгалаа нэгэндээ шилжүүлж болно гээд байна уу, үгүй юу?

Хангай: - Тийм. Тухайн хүний авсан эмчилгээ, үйлчилгээний зардлын хэмжээ эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх дээд хязгаар(2 сая төгрөг)-аас хэтэрвэл гэр бүлийнхээ өөр гишүүний зардлаас нэг удаа шилжүүлэн тооцуулах боломжтой болж байгаа гэсэн. Сайхан байгаа биз?

Жишээ: Хэрвээ та тухайн жилд дараах тусламж, үйлчилгээ авсан гэвэл:



Эрүүл мэндийн даатгалтай бол:

Тусламж үйлчилгээ	Өөрөө төлөх	Даатгалаас төлөх
Эмнэлэгт хэвтсэн	120 600	683 500
Сувилалд	400 000	115 000
Өдрийн эмчилгээ		135 000
Оношилгоо		55 000
Амбулатори		15 000
Эмийн үнийн хөнгөлөлт	4 500	18 000
Уламжлалт эмчилгээ	11 700	105 000
Нийт зардал	536 800	1 126 800

Эрүүл мэндийн даатгалгүй бол:

Тусламж үйлчилгээ	Өөрөө төлөх
Эмнэлэгт хэвтсэн	804 000
Сувилалд	515 000
Өдрийн эмчилгээ	135 000
Оношилгоо	55 000
Амбулатори	15 000
Эмийн үнийн хөнгөлөлт	22 500
Уламжлалт эмчилгээ	117 000
Нийт зардал	1 663 600

Дээрх жишээнээс харахад хэрэв та эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй байсан бол нийтдээ 1 663 600 төгрөгийг эмнэлэг, сувилал, эмийн санд өөрөө хувиасаа төлөх байсан. Харин эрүүл мэндийн даатгалд хамрагдаж жилдээ шимтгэлд 46 080 төгрөг төлснөөр дээрх зардлын 1 126 800 төгрөгийг нь эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх боломж бүрдэж байгаа юм.



Ганаа: - Бидний төлсөн 46 080 төгрөгний төлөө яаж ийм их тусламж үйлчилгээ үзүүлдэг юм бол?

Насан: - Чи өвдөөгүй байхдаа бусад, чамайг өвдвөл бусад хүмүүс чамд тусалж байна гэсэн үг. Эрүүл мэндийн даатгалд манай улсын бүх иргэд, дээр нь энд гэрээгээр хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэд ч заавал даатгуулах ёстой. Өвчлөх, бэртэж гэмтээд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах явдал маш түгээмэл тохиолддог. Тийм ч учраас хүн бүрийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, эрүүл мэндийн тусламж,

үйлчилгээ авах боломжийг нь бүрдүүлэх бодлогыг төрөөс баримталж байгаа юм. Хүүхэд, ахмад настнуудын эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс 100 хувь хариуцан төлж байгаа нь ч үүнтэй холбоотой.

Ганаа: - Тэгвэл ч хамгийн олон хүн хамрагддаг даатгал юм байна даа. Батаа чи ч гэсэн одоо шимтгэлээ төлөх нь зөв шүү.

Насан: - Тиймээ. Бид бүгдээрээ эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээ хуваалцаж, дэм дэмэндээ л яваа гэсэн үг ...

3.2. Малчин эрүүл мэндийн даатгалд яаж даатгуулах вэ?

Малчид сумынхаа нийгмийн даатгалын байцаагч дээр очин эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ нээлгэх ба шимтгэлээ тогтмол хугацаанд төлж баталгаажуулснаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрөө эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх эрхтэй болно.



Зураг 12. Эрүүл мэндийн даатгалаас тусламж үйлчилгээний төлбөр, эмийн хөнгөлөлт авах эрх үүсэх явц

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээ. Малчин-даатгуулагч нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2 хувиас доошгүй хэмжээгээр тогтоогдсон шимтгэлийг улирал бүр, эсвэл жил бүр өөрөө хариуцан төлнө.

Хэрвээ Та эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ илүү төлсөн бол эргүүлэн авах, эсхүл дараа төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлд тооцуулах боломжтой байдаг. 2016 онд төлөх шимтгэлийн мөнгөн дүнг дараах хүснэгтээс харна уу.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээ (төгрөг)		
Малчин-даатгуулагч	Сард	Жилд
	3 840	46 080

Төрөөс дараах иргэдийн эрүүл мэндийн даатгалыг хариуцан төлнө. Үүнд:

- 0-18 насны хүүхэд
- Тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн
- Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүд
- Хүүхдээ 2 (ихэр бол 3) нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх/эцэг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
- Ял эдэлж байгаа ялтан
- Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч



- Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрсдөө хариуцан төлөх бөгөөд 2016 онд сард 1 920, жилд 23 040 төгрөг төлөхөөр тогтоосон.

Бат:

- Өвчлөөд эмнэлгээр явах үед эрүүл мэндийн даатгалаа төлөөгүй байвал яах вэ?

Насан:

- Өөрөө мөнгө төлөөд л төлбөртэй үйлчилгээ авах байхдаа. Маш их зардал гарна шүү. Хөдөөгийн бид чинь даатгалгүй бол төлбөрөө төлөөд ч бүх үйлчилгээг авах боломж тэр бүр байхгүй. Тиймээс л жилийн шимтгэлээ хугацаанд нь тогтмол төлөөд эмчилгээний зардлаа ч аваад явах хэрэгтэй. Батаа чи энэ материалыг аваад яв. Гэрийнхэнтэйгээ ярилц. Тэгээд гэрчилгээгээ нээлгэх үедээ асууж тодруулах юмаа бэлдээд ирээрэй. Эрүүл мэндийн даатгалын туршлагатай даатгуулагч гэлтгүй Ганаа, Болороо хоёр ч гэсэн эндээс авч яваад танилц. Шинэ мэдээлэл нэлээд орсон байгаа.



Та гэрээгээр тохирсон хугацаанд эрүүл мэндийн даатгалын **шимтгэлээ тогтмол төлөх** үүрэгтэй. Хэрвээ тухайн жилийн шимтгэлээ төлөөгүй тохиолдолд шимтгэлийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгууль төлнө.



- Хоёр хүүхдийн маань эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг 19 нас хүртэл нь төр төлчих юм байна. Бид хоёрынх жилд 92 060 төгрөг болох юм байна. Ингэснээрээ манай гэр бүл жилдээ 8 сая төгрөгийн эмчилгээ, үйлчилгээний зардлыг даатгалаас төлүүлэх нь байна шүү дээ. Батаа танайх ч бас адилхан болох нь дээ.



- Тийм байна. Нийгмийн даатгалаа ноолуур гарахаар хавар, эрүүл мэндийн даатгалаа мал махны үеэр нэг удаа л төлж байх нь зүгээр юм уу?

Эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ ямар хэрэгтэй вэ? Эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ нь таныг шимтгэл төлж, даатгуулсныг гэрчилж эмнэлэг, сувиллаас тусламж, үйлчилгээ авахад төлбөрийн хөнгөлөлт, эмийн сангаас эм авахад үнийн хөнгөлөлт эдлэх эрхийн баталгаа юм.



3.3. Эрүүл мэндийн даатгалд хамаарах эмчилгээ, үйлчилгээ, зардлын төлбөр

Эрүүл мэндийн даатгалд хамаарах эмчилгээ, үйлчилгээ. Эрүүл мэндийн даатгалаас дараах эмчилгээ, үйлчилгээний зардлыг төлнө. Үүнд:

Эрүүл мэндийн даатгалд хамаарах тусламж, үйлчилгээ



Хэвтүүлэн
эмчлэх
тусламж
үйлчилгээ



Амбулаторийн
тусламж
үйлчилгээ



Уламжлалтын
тусламж
үйлчилгээ



Сэргээн
засах
тусламж
үйлчилгээ



Хорт хавдрын
болон бусад
өвчний хөнгөвчлөх
эмчилгээ



Оношилгоо,
шинжилгээ



Өдрөөр
эмчлэх
тусламж
үйлчилгээ



Өндөр өртөгтэй
зарим тусламж,
үйлчилгээнд
шаардлагатай
эмнэлгийн хэрэгсэл
цорго, протез,
ортопед



Эмийн үнийн
хөнгөлөлтийн
үйлчилгээ



Хорт хавдрын
өдрийн
хими, туяа
эмчилгээ



Жирэмсний 37
долоо хоногоос
өмнөх ба төрсний
дараах үеийн
хавсарсан эмгэгийн
эмчилгээ

Эрүүл мэндийн даатгалаас хариуцах зардлын хэмжээ. Даатгуулагч ЭМД-ын гэрээ байгуулсан төрийн өмчийн болон хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэхэд эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах төлбөрийн хэмжээг тусламж, үйлчилгээний төрлөөр нь дараах хүснэгтэд харуулав.

Эрүүл мэндийн даатгалаас хариуцах төлбөр (төгрөг)		
Тусламж, үйлчилгээний төрөл	Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага	Хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллага
Хэвтүүлэн эмчлэх	145 500 – 804 090	84 875 – 469 052
Өдрөөр эмчлэх	65 475 – 158 895	-
Амбулаторийн үйлчилгээ	15 000 – 16 200	-
Нөхөн сэргээх эмчилгээ	110 000 – 116 281	110 000 – 116 281
Оношилгоо, шинжилгээ	55 000	-
Уламжлалт эмчилгээ	117 000	117 000
Хөнгөвчлөх үйлчилгээ	300 000	175 000
Хорт хавдрын химийн өдрийн эмчилгээ (тохиолдолд)	450 000	-
Хорт хавдрын туяаны өдрийн эмчилгээ (өдөрт)	66 000	-
Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, хиймэл цорго, протез, ортопед	975 - 28 740 750	-

Эмийн үнийн хөнгөлөлт. Өрх, сум, баг, аймаг, дүүргийн амбулаторийн төрөлжсөн мэргэжлийн эмчийн бичсэн жороор нийгмийн даатгалын байгууллагатай гэрээ бүхий эмийн сангаас авах 171 нэр төрлийн 652 эмийн үнийн 40-80 хувь буюу 500 - 125 000 төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлнө.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлаас даатгуулагч өөрөө хариуцан төлөх төлбөр. Даатгуулагч нь эмнэлэгт хэвтэж эмчлүүлэхдээ эмнэлгийн төлбөрийн 10-15 хувийг буюу 14 550 - 120 613 төгрөгийг өөрөө, харин үлдэх 85-90 хувийг буюу 123 675 - 723 681 төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сан хариуцан төлнө.

Жишээлбэл, малчин "А" нь улсын нэгдүгээр төв эмнэлэгт нойр булчирхайн мэс заслын тусламж, үйлчилгээ авсан бол даатгуулагч болон даатгалын байгууллага нь дараах зардлыг тухайн эмнэлэгт төлнө.

Хамтын төлбөр (төгрөг)			
Эмчилгээ	Эмчилгээний зардал	Үүнээс:	
		Малчин "А" төлөх	Эрүүл мэндийн даатгалын байгууллага төлөх
Нойр булчирхайн мэс засал	655 860	98 379	557 481

Эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн дээд хязгаар. Та эрүүл мэндийн даатгалын сангаас жилдээ 2 сая хүртэл төгрөгийн зардлыг төлүүлэх боломжтой.

Хэрвээ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөр тань тухайн жилийн дээд хязгаар 2 сая төгрөгөөс хэтэрсэн тохиолдолд гэр бүлийн өөр нэг даатгуулагч- гишүүний зөвшөөрснөөр, түүний зардлаас жилд нэг удаа шилжүүлэн тооцуулах боломжтой. Жишээлбэл, Хангай эхнэр, хүүхдийн хамт амьдардаг. Ам бүл 4. Тэрээр 2016 онд дараах тусламж, үйлчилгээ авчээ. Үүнд:

Тусламж, үйлчилгээ авсан хугацаа	Эрүүл мэндийн байгууллага	Авсан тусламж, үйлчилгээ	Оношийн бүлгээс хамаарсан тусламж, үйлчилгээний өртөг (төгрөг)	Тухайн эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн даатгалын сангаас төлсөн төлбөр (төгрөг)
1 сар	Улсын 3 дугаар төв эмнэлэг	Зүрхний мэс засал	804 090	683 476
2 сар	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	Зүрхний хавхлагын эмчилгээ	242 970	218 673
3 сар	Оргил рашаан сувилал	Нөхөн сэргээх эмчилгээ	116 281	116 281
1, 4, 7 сар	Дүүргийн эрүүл мэндийн нэгдэл	Амбулаторийн үзлэг	15 000	90 000
5, 8, 11 сар	Баянзүрх эмнэлэг	Даралт ихсэх өвчний өдрийн эмчилгээ	144 234	432 702
1, 4, 7 сар	Дүүргийн эрүүл мэндийн нэгдэл	Оношилгоо, шинжилгээ	165 000	495 000
2, 4, 7, 8, 10, 12 сар	"Монос" эмийн сан	Эмийн үнийн хөнгөлөлт		300 000
НИЙТ				2 336 132

Хангайн нийт зардал эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн дээд хязгаар 2 сая төгрөгөөс 336 132 төгрөгөөр хэтэрсэн тул Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу даатгуулагч-эхнэрийнхээ зардлаас 336 132 төгрөгийг нэг удаа шилжүүлэн тооцуулах боломжтой юм. Энэхүү үйлчилгээ нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчид хамааралтай. Харин эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төрөөс хариуцдаг (хүүхэд, ахмад настан зэрэг) иргэд ийнхүү шилжүүлэн авах боломжгүй.

ДҮГНЭЛТ:

- Эрүүл мэндийн даатгал, түүний ач холбогдол
- Малчид эрүүл мэндийн даатгалд хамрагдах арга зам
- Малчдын төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээ төлөх хугацаа
- Эрүүл мэндийн даатгалд хамаарах эмчилгээ, үйлчилгээ
- Эрүүл мэндийн даатгалаас хариуцах төлбөр
- Эрүүл мэндийн даатгалын байгууллага, даатгуулагч хоёр хамтарч төлөх хамтын төлбөрийн талаар тодорхой мэдээлэл авч ярилцлаа.



Одоо мэдлэгээ бататган цэгцлэх дасгал ажиллаарай. Суралцагч Та эхлээд "Нийгмийн даатгал" бүлгийг үзэж байхдаа хийж эхэлсэн зурагтай номоо "Эрүүл мэндийн даатгал" бүлгээр үргэлжлүүлэн хийгээрэй. Номоо хэрхэн бүтээх, ашиглах, баяжуулах тухай санамжийг "Нийгмийн даатгал" бүлгийн мэдлэгээ бататгах дасгалаас харна уу (Хуудас 34).



Дараах зургийн жижиг зургуудыг зохих байрлалтай нь холбон зураарай. Чиглүүлэг:

а. Дараах зургийг эхлээд сайн ажиглаарай.

б. Зургийг тойруулан улаанаар бичсэн 2 асуултыг уншаарай. Тэгээд хэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төр, хэн өөрөө төлдөг болохыг өмнөх зургуудаас ялган зохих байрлалтай нь холбон зураарай.



хүүхэд
(0-18 нас)



малчин



цэрэг



оюутан



хүүхдээ
асарч буй эх



өндөр
настан

- Хэний эрүүл мэндийн даатгалыг төрөөс төлдөг вэ?




- Хэн эрүүл мэндийн даатгалаа өөрөө төлөх ёстой вэ?





"Эрүүл мэндийн даатгал" бүлгээс малчдад хамгийн чухал мэдээллийг түүж товч бичээрэй.



Танай гэр бүл эрүүл мэндийн даатгалд даатгуулснаар ямар ач холбогдолтой болохыг дүгнэн ярилцаарай.

Чиглүүлэг:

- Гэр бүлийн хэн нэг нь өвчлөхөд ямар хэмжээний зардал гарч байсныг санаж байна уу? Эрүүл мэндийн даатгалаас ашигласан уу?
- Эрүүл мэндийн даатгалаа ашиглан шаардлагатай тусламж, үйлчилгээг цаг алдалгүй авах нь та бүхний эрүүл мэндэд ямар нөлөөтэй вэ?
- Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг сайжруулахад юу хэрэгтэй гэж боддог вэ?



Суралцагч та "Эрүүл мэндийн даатгал" бүлгийг үзээд, ямар амжилтад хүрсэн талаар "Амжилтын түүх"-ээ бичээрэй. Бичих загварыг 35 дугаар хуудаснаас харна уу.

“Эрүүл мэндийн даатгал” сэдвийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадвар, өөртөө болон гэр бүлдээ гарч буй өөрчлөлт дэвшлийг үнэлнэ үү.

Зөвшөөрч буй хариуны харгалзах нүдийг будаарай. Жишээг харна уу.

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1. Хүүхдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг 19 нас хүртэл нь төр хариуцан төлнө.			
2. Эрүүл мэндийн даатгалын сангаас даатгуулагч эмчилгээ, үйлчилгээний бүх зардлаа төлүүлж болно.			
3. Уламжлалт эмчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас төлөхгүй.			
4. Малчин сард 1 920 төгрөг, жилд 23 040 төгрөгийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлнө.			
5. Оюутан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахын тулд эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө төлсөн байх ёстой.			
6. Даатгуулагч эрүүл мэндийн даатгалын сангаас жилдээ 2 сая хүртэл төгрөгийн зардлыг төлүүлэх боломжтой.			
7. Малчин эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ сар бүр төлнө.			
8. Эрүүл мэндийн даатгалын сангаас даатгуулагчид эмийн үнийн хөнгөлөлт үзүүлнэ.			
9. Би эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сайн ойлгож, даатгуулсан.			
10. Би эрүүл мэндийн даатгалтай байсан. Шимтгэлээ хугацаанд нь төлж байгаа.			

ТАЙЛБАР: Та дээрх хүснэгтэд сонгож будсан хариугаа шалгахдаа энэ номын ард хавсаргасан хариутай тулгаж үзээрэй (Хуудас 55, Хавсралт 4.3-б, Хүснэгт 2).

ҮНЭЛГЭЭ

Бүх хариу таарч байвал	Хангалттай сайн
2-3 зөрж байвал	Хангалттай
3-аас дээш зөрж байвал	Сэдвээ дахин үзнэ үү.

НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ

Нэгдсэн үнэлгээ нь бие даан суралцах явцад эзэмшсэн мэдлэгээ хэрэглэж байгаа эсэхийг танадах зорилготой бөгөөд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ, үр дүнгээр үнэлэх аргыг хэрэглэнэ.

Нэг. Өөрийн үнэлгээ. Дараах асуултуудад хариулж өөрийгөө үнэлээрэй.

1. Та энэхүү гарын авлагаар бие даан суралцах явцад их зүйл сурсан уу?
2. Гарын авлагынхаа болон бусад материалыг ашиглан бяцхан зурагтай ном хийсэн үү?
3. Хийсэн номоо ашиглаад хэн нэгэнд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын талаар ярьж өгсөн үү? Хэрвээ ярьсан бол нөгөө хүнд чинь таалагдсан уу?
4. Танаар яриулсан хүн танаас дахин асууж зөвлөгөө авахыг хүссэн үү?
5. Таны хийсэн бяцхан номыг үзсэн хүмүүс таныг магтаж урам өгсөн үү?
6. Та хийсэн, сурсан бүхэндээ сэтгэл хангалуун байна уу?
7. Цаашдаа сурсан зүйлдээ тулгуурлан нийгмийн даатгалын талаарх мэдлэгээ улам гүнзгийрүүлэх бодол байна уу?
8. Хэрвээ таныг баг, хоршооны бусад хүмүүст нийгмийн даатгалын талаар ярьж өгөөч гэвэл та зөвшөөрөх үү? Та тийм хэмжээнд хүрсэн үү, өөрийгөө юу гэж үнэлж байна вэ?
9. Та энэ гарын авлагаар сурсан зүйлээ ашиглан өөрийгөө болон гэр бүлээ болзошгүй эрсдэлээс хамгаалж чадах уу?
10. Таныг бие даан суралцаж байхад танай гэр бүлийнхэн дэмжсэн үү?

Үнэлэх заавар:

8-аас дээш асуултад "ТИЙМ" гэж хариулсан бол	Хангалттай сайн
6-7 асуултад "ТИЙМ" гэж хариулсан бол	Хангалттай
5 хүртэл асуултад "ТИЙМ" гэж хариулсан бол	Сэдвээ дахин үзнэ үү.

Хоёр. Хөндлөнгийн үнэлгээ. Таныг бие даан суралцаж, бусадтай санал бодлоо хуваалцаж байхад тань "Чи нийгмийн даатгалын талаар их юм мэддэг болжээ, эсвэл" гэх мэтээр хэн нэгэн таныг үнэлж дүгнэж байсан л байж таараа. Түүнийг болон чиглүүлэгч багш, нийгмийн даатгалын байцаагч нар танд үнэлгээ, дүгнэлт өгч байсан бол эргэн санаарай.

Гурав. Үр дүнгийн үнэлгээ. Та бие даан суралцаад ямар үр дүнд хүрснээ нэгтгэн дүгнээрэй. Өөртөө үнэлэлт дүгнэлт өгөх чиглүүлэгч:

- Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг цаг тухайд нь төлж яваад эрсдэлд өртсөн үедээ үр шимийг нь хүртэнэ гэдэгт итгэлтэй болсон эсэх
- Өөрийнхөө сурах чадварт итгэн, урам зориг орж сэтгэл хангалуун байгаа эсэх
- Сурсан зүйлээ бусадтай хуваалцах, зааж сургах хүсэлтэй болсон эсэх
- Нийгмийн даатгалын ач холбогдлын талаар малчдыг мэдээллээр хангах ажлыг сайжруулах талаар сум, багийн удирдлага, нийгмийн даатгалын байцаагчид санал тавьсан эсэх
- Таныг гэр бүлийнхэн чинь хүлээн зөвшөөрч, тусалж дэмжиж байгаа эсэх.

Тэжээгчээ алдсаны тэтгэврийг хэн авах вэ?

Даатгуулагч нас барвал түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй дор дурдсан гишүүд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй:

1/ хууль ёсоор тэжээх өөр хүн байгаа эсэхийг харгалзахгүйгээр төрүүлсэн буюу үрчлэн авсан 19 нас хүрээгүй хүүхэд /үүнд эцгээ нас барснаас хойш мэндэлсэн, төрсөн хүүхэд нь хамаарна/;

2/ хууль ёсоор тэжээх өөр хүнгүй 19 нас хүрээгүй ач, зээ, төрсөн дүү;

3/ тэжээгчийн асрамжид байсан төрөлхийн тахир дутуу буюу 16 нас хүрээгүй байхдаа тахир дутуу болсон хүүхэд, ач, зээ, төрсөн ах, эгч, дүү;

4/ эрэгтэй нь 60, эмэгтэй нь 55 нас хүрсэн буюу эсхүл тахир дутуу болсон эцэг, эх, эхнэр, нөхөр, хууль ёсоор тэжээх өөр хүнгүй өвөг эцэг, эмэг эх, төрсөн ах, эгч, дүү;

5/ найман нас хүрээгүй хүүхэд, хууль ёсоор асрах хүнгүй төрсөн дүү, ач, зээг нь асарч ажил хийгээгүй байгаа эцэг, эх буюу нөхөр, эхнэрийн аль нэг /нас, хөдөлмөрийн чадварыг харгалзахгүйгээр/;

6/ өндөр насны, эсхүл тахир дутуугийн тэтгэвэр авч байгаад нас барсан, түүнчлэн нас барахын өмнөх саруудад хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан даатгуулагчийн гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд;

7/ дагавар хүүхэд нь тэжээгч байгаад нас барсан бол хойт эцэг, эх нь төрсөн эцэг, эхийн адил;

8/ төрсөн эцэг, эхээс шүүхийн шийдвэрээр тэтгэлэг авдаггүй хүүхэд хойт эцэг буюу эхийгээ нас барахад төрсөн хүүхдийн адил;

9/ даатгуулагч сураггүй алга болсон нь шүүхийн шийдвэрээр тогтоогдож, уг шийдвэр хүчинтэйд тооцогдсон тохиолдолд түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд.

Эх сурвалж:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
2. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль

Хавсралт 4.2

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/107 дугаар тушаалын хавсралт



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

НД № 10

Хянаж, баталгаажуулсан:
/албан тушаалын нэр/ /гарын үсэг/ /огноо/

НИЙГМИЙН ДААТГАЛД САЙН ДУРААР ДААТГУУЛСАН ТУХАЙ ГЭРЭЭ

Дугаар

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Иргэний хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийн холбогдох заалтын дагуу нийгмийн даатгалд сайн дураар даатгуулахаар нэг талаас. аймаг /дүүрэг/ /сум/-ийн нийгмийн даатгалын хэлтэс /тасаг/-ийн байцаагч эцэг (эх)-ийн нэр өөрийн нэр /цаашид “нийгмийн даатгалын байцаагч” гэнэ/, нөгөө талаас. эцэг (эх)-ийн нэр өөрийн нэр /цаашид “даатгуулагч” гэнэ/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2.Даатгуулагчийн регистрийн дугаар:

--	--	--	--	--	--	--	--	--	--

1.3.Нийгмийн даатгалын дэвтрийн дугаар:

--	--	--	--	--	--	--	--

1.4. Хөдөлмөр эрхлэлтийн байдал: (тохирох хэсгийн ард (√) тэмдэглэнэ)

1	Хувиараа бизнес эрхлэгч	
2	Гадаадын төслийн нэгжид ажилладаг иргэн	
3	Жолооч (такси, зорчигч болон ачаа, хот хоорондын тээврийн жолооч)	
4	Бичил уурхай эрхлэгч	
5	Газар тариалан эрхлэгч (ногоочин)	
6	Малчин	
7	Оюутан (бакалавр, магистр, докторант, бусад)	
8	Захиргааны цалингүй чөлөө түр хугацаанд авсан иргэн	
9	Гадаад улс оронд оршин суугч иргэн	
10	Ажилгүй иргэн	
11	Бусад	

1.5. Гэрээний хугацаа(1-12 сар дуустал байна.): сар

1.6. Гэрээний хүчинтэй байх хугацаа:
/эхлэх / (он, сар, өдөр)/ / дуусах/ (он, сар, өдөр)/

Тайлбар: Гэрээний эхлэх огноо нь даатгуулагчийн төлсөн шимтгэл даатгалын санд орсон өдөртэй адил байна.

1.7. Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс: төгрөг.

Доод хэмжээ=Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (ХХДХ);

Тайлбар: Даатгуулагчийн өөрөө мэдүүлсэн орлогын доод хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, Засгийн газраас баталсан нийгмийн даатгалын шимтгэл төлөх хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээнээс ихгүй байна.

1.8. Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ: 12% (тэтгэврийн даатгалд 10%, тэтгэмжийн даатгалд 1%, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд 1%)

1.9. Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөр тохирсон хугацаа:
(тохирох хэсгийн ард (✓) тэмдэглэнэ)

а.Сар бүр	б.Улирал бүр	в.Хагас жилээр	г.Бүтэн жилээр
-----------	--------------	----------------	----------------

1.10. Гэрээ байгуулсан талууд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, шимтгэл төлөх хугацаа, сунгалтыг уг гэрээний хавсралтад нарийвчлан тусгана. Энэхүү хавсралт нь уг гэрээний салшгүй хэсэг мөн.

1.11. Даатгуулагч гэрээ байгуулж, даатгуулагчийн шилжүүлсэн шимтгэл нийгмийн даатгалын дансанд орсон өдрөөс эхлэн шимтгэл төлсөн хамгийн сүүлийн хугацааг нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан хугацаанд тооцно.

1.12. Энэ гэрээний 1.7-д заасан нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлсний хэмжээ гэрээний хугацаанд өөрчлөгдөхгүй. Үүнд шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоосон нь хамаарахгүй.

Хоёр. Нийгмийн даатгалын байгууллага /байцаагч/-ийн эрх, хүлээх үүрэг

2.1. Гэрээг анх байгуулсан болон сунгах өдрөөс эхлэн тооцож 1 сараас доошгүй хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг даатгуулагчаар бэлэн бусаар төлүүлнэ.

2.2. Нийгмийн даатгалын байцаагч нь даатгуулагч /иргэн/-ийг даатгуулах хүсэлтээ гарган эхний сарын шимтгэл төлсөн тохиолдолд нийгмийн даатгалд даатгуулсан тухай гэрээг байгуулж, нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

2.3.Нийгмийн даатгалын байгууллагын харилцах дансанд даатгуулагчийн төлсөн шимтгэлийн хэмжээг нийгмийн даатгалын дэвтэрт бичиж, мэдээллийн санд бүртгэж, тооцоо хийн, хянаж баталгаажуулна.

2.4. Даатгуулагч шимтгэлээ энэ гэрээний 1.9-д тохирсон хугацаандаа төлөөгүй, эсхүл дутуу төлсөн тохиолдолд Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу дутуу төлсөн буюу хугацаандаа төлөгдөөгүй шимтгэлийг нөхөн төлүүлж, шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0,3 хувийн алданги ногдуулна.

2.5. Гэрээгээр тохиролцсон шимтгэлийг хугацаанд нь төлүүлэх талаар даатгуулагчид урьдчилан мэдэгдэх, сануулах арга хэмжээ авч болно.

2.6. Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэл тооцох орлогоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байхаар мэдүүлсэн тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдвөл даатгуулагчид мэдэгдэн гэрээнд өөрчлөлт оруулна. Харин нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах орлогоо хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээтэй тэнцүү байхаар мэдүүлсэн даатгуулагч хүсвэл нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах орлогод өөрчлөлт оруулж болно.

2.7. Даатгуулагч өөр аймаг (дүүрэг), суманд шилжих, ажилд орох, өндөр насны тэтгэвэр тогтоолгох тохиолдолд шимтгэлийн тооцоог дуусгаж, нийгмийн даатгалын дэвтэрт бичилт хийж, баталгаажуулан сайн дураар даатгуулсан гэрээг дуусгавар болсонд тооцож, даатгуулагчийн хувийн хэрэг, холбогдох материалыг архивт хадгалуулна.

2.8. Даатгуулагчийн төлөх шимтгэлийг нийгмийн даатгалын байцаагч бэлэн мөнгөөр авахыг хориглоно.

Гурав. Даатгуулагчийн эрх, хүлээх үүрэг

3.1. Даатгуулагч нь гэрээний хугацаанд мөрдөгдөх нийгмийн даатгалын шимтгэл тооцох сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоо энэ гэрээний 1.7-д заасны дагуу тохиролцож, түүнд ногдох шимтгэлийг энэхүү гэрээний 1.8-д заасан хувь хэмжээгээр тооцож бэлэн бусаар, энэхүү гэрээний 1.9-д заасан хугацаагаар хавсралтад заасан хуваарийн дагуу сар (улирал, хагас жил, жил) бүр төлнө.

3.2. Даатгуулагчийн өөрөө мэдүүлсэн сарын орлогын хэмжээ нь тухайн үед мөрдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, дээд хэмжээнээс ихгүй байна.

3.3. Даатгуулагч шимтгэл төлөх хугацаагаа гэрээнд тусгаж, шимтгэлээ сар бүр төлөхөөр гэрээ байгуулсан бол сар бүр, улирлаар бол улирлын эхний сард, хагас жилээр бол хагас жилийн эхний сарын гэрээ байгуулсан өдөрт багтааж төлнө. Харин жилээр гэрээ байгуулж шимтгэлийг жилээр төлөх бол энэхүү гэрээний 2.1, 3.4-т дурдсан 1 сарын шимтгэлийг гэрээ байгуулах үед төлөх ба гэрээний хугацаанд жилийн аль ч сард нэг удаа төлөхөөр гэрээнд тусгаж болно.

3.4. Гэрээ байгуулах, сунгах өдрөөс эхлэн тооцож 1-ээс доошгүй сарын нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн байна.

3.5. Шимтгэл тооцох орлогын хэмжээг энэхүү гэрээний 2.6-д зааснаас бусад тохиолдолд гэрээний хүчинтэй хугацаанд өөрчлөхгүй. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож шимтгэл төлж байсан даатгуулагч шимтгэл төлөх орлогын доод хэмжээ өөрчлөгдсөнөөс үүссэн шимтгэлийн зөрүүг нөхөж төлнө.

3.6. Гэрээний хугацааг сунгах эсхүл энэхүү гэрээний 3.7, 3.8, 3.9-д дурдсан шалтгаанаар гэрээг дуусгавар болгох тухай хүсэлтээ даатгуулагч нийгмийн даатгалын

байгууллага /байцаагч/-д тавьж шийдвэрлүүлнэ. Гэрээг сунгах үед гэрээний загвар шинэчлэгдсэн, тухайн үед мөрдөж буй хөдөлмөрийн хөлсний доод, дээд хэмжээ, өмнөх шимтгэл төлөх орлогын хэмжээ, төлөх хуваарьт өөрчлөлт орсон, тухайн даатгуулагчийн ургийн овог, эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, хаяг өөрчлөгдсөн бол гэрээг дуусгавар болгож шинээр гэрээ байгуулна.

3.7. Өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй хөдөлмөрийн гэрээгээр ажилд орсон бол нийгмийн даатгалын байгууллага /байцаагч/-д мэдэгдэж мөн өдрөөс эхлэн гэрээний хугацааг дуусгавар болгон шимтгэлийн тооцоог дуусгана.

3.8. Гадаад улсад ажиллаж, амьдрахаар явах тохиолдолд харилцагч нийгмийн даатгалын байгууллагад хандан шимтгэлийн тооцоог хийж, гэрээний хугацааг үргэлжлүүлэн сунгах эсэхээ харилцан тохиролцоно.

3.9. Өөр аймаг (дүүрэг), суманд шилжсэн тохиолдолд төлсөн шимтгэлийн тооцоог нийгмийн даатгалын хэлтэс /тасаг, байцаагч/-тэй хийж гэрээний хугацааг дуусгавар болгож, нийгмийн даатгалын дэвтэрт бичүүлэн баталгаажуулж авна.

3.10. Даатгуулагч гэрээний хүчинтэй хугацаанд энэхүү гэрээний 4.3-т дурдсанаас бусад шалтгаанаар гэрээг дуусгавар болгохгүй. Даатгуулагч шимтгэл төлсөн банкны орлогын баримтад эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, регистрийн дугаар, хэдэн оны аль сар /улирал, хагас жил, жил/-ын шимтгэл төлж байгааг тодорхой бичнэ. Дурдсан мэдээлэл, банкны нэр, дансны дугаарыг үнэн зөв бичээгүйгээс үүдэн гарах хариуцлагыг даатгуулагч хүлээнэ.

3.11. Даатгуулагч нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд заасан болзол нөхцөлийг хангасан бол тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал авах эрхтэй.

3.12. Даатгуулагч энэхүү гэрээний 1.5-д заасан хугацаанд Өмчийн бүх хэвшлийн аж ахуй нэгж, байгууллага, төрийн, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээ байгуулж ажилласан боловч энэхүү гэрээний 1.5-д заасан хугацаа дуусахаас өмнө ажлаа дуусгасан бол сайн дурын даатгалын гэрээг үргэлжлүүлэн нийгмийн даатгалын шимтгэл төлж, даатгуулж болно.

3.13. Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлээ банкны цахим үйлчилгээ ашиглан интернет, гар утаснаас төлж болно.

Дөрөв. Гэрээг сунгах, дуусгавар болгох, өөрчлөлт оруулах

4.1. Талууд харилцан тохиролцож энэхүү гэрээг нэг удаа сунгаж болно.

4.2. Даатгуулагч гэрээний хугацаа дууссанаас хойш дараагийн 1 сард багтаан энэхүү гэрээний 2.1, 3.3-т заасан шимтгэл төлж, уг шимтгэл нь даатгалын санд орсон бол анх гэрээ байгуулсан хугацаагаар гэрээг 1 /нэг/ удаа сунгасанд тооцно.

4.3. Даатгуулагч ажилд орсон, өөр аймаг (дүүрэг), суманд шилжсэн, нас барсан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон бол гэрээний хугацааг дуусгавар болгоно.

Тав. Маргааныг шийдвэрлэх, хүлээх хариуцлага

5.1. Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдсон маргаантай асуудлыг харилцан зөвшилцөн шийдвэрлэх зарчим баримтлах бөгөөд шаардлагатай гэж үзвэл тогтоосон журмын дагуу Гомдлын шаардлагын зөвлөлөөр шийдвэрлүүлнэ.

5.2. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэг болон нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг зөрчвөл холбогдох хуульд заасны дагуу зохих хариуцлага тооцно.

Зургаа. Бусад

6.1. Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж нэг хувийг нийгмийн даатгалын байгууллагад, нөгөө хувийг гэрээ байгуулсан даатгуулагчид өгөх ба хувь тус бүр хүчин төгөлдөр болно.

Гэрээ байгуулсан:

**Нийгмийн даатгалын байгууллагыг
төлөөлж:**

..... аймаг/дүүрэг/
сумын
нийгмийн даатгалын байцаагч

..... /..... /
/гарын үсэг/ /гарын үсгийн тайлал /

Хаяг:
.....

Утас:

Э-шуудангийн хаяг:

201 ... оны ... сарын ... өдөр

Даатгуулагчийг төлөөлж:

..... аймаг/дүүрэг/
сумын
... хороо /баг/-ны оршин суугч

..... /..... /
/гарын үсэг/ /гарын үсгийн тайлал /

Хаяг:
.....

Утас:

Э-шуудангийн хаяг:

201 ... оны ... сарын ... өдөр

Өөрийгөө үнэлэх асуулгын хариу

Хүснэгт 1. "НИЙГМИЙН ДААТГАЛ" сэдвээр өөрийгөө үнэлэх асуулгын хариу

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1. Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа болон шимтгэл тооцсон орлогын хэмжээ нь авах тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээнд нөлөөлнө.			
2. Малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нэг жилийг нэг жил хоёр сараар шимтгэл төлсөн хугацаанд тооцно.			
3. Нийгмийн даатгал 4 төрөлтэй, төрөл тус бүр нь бие даасан мөнгөн хөрөнгийн сантай байна.			
4. 20 жилээс дээш хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн жил тутамд 1.5 хувиар, сар тутамд 0.125 хувиар өндөр насны тэтгэвэр тогтоолгосон хөдөлмөрийн хөлснөөс тооцож нэмэгдэл олгоно.			
5. 50 нас хүрсэн эмэгтэй 4 хүүхэдтэй боловч заримыг нь үрчилж авч өсгөсөн бол хүүхдийн болзлоор өндөр насны тэтгэвэр тогтоолгож болохгүй.			
6. Хөдөө аж ахуйн нэгдэлд ажиллаж байсан хугацааг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн жил дээр нэмж тооцдог.			
7. Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг жирэмсний чөлөө авахаас өмнө 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн даатгуулагч жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй.			
8. Сайн дураар даатгуулсан эхийн шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, орлогын дунджаас 50 хувиар тооцон 4 сарын хугацаанд жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгоно.			
9. Тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгох бол даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын тухай Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр шаардлагатай.			
10. Би нийгмийн даатгалын ач холбогдлыг сайн ойлгож, сайн дураар даатгуулсан.			
11. Би нийгмийн даатгалд өмнө нь даатгуулсан байсан. Шимтгэлээ хугацаанд нь төлж байгаа.			

Хүснэгт 2. “ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ” сэдвээр өөрийгөө үнэлэх асуулгын хариу

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1. Хүүхдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг 19 нас хүртэл нь төр хариуцан төлнө.			
2. Эрүүл мэндийн даатгалын сангаас даатгуулагч эмчилгээ, үйлчилгээний бүх зардлаа төлүүлж болно.			
3. Уламжлалт эмчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас төлөхгүй.			
4. Малчин сард 1 920 төгрөг, жилд 23 040 төгрөгийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлнө.			
5. Оюутан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахын тулд эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө төлсөн байх ёстой.			
6. Даатгуулагч эрүүл мэндийн даатгалын сангаас жилдээ 2 сая хүртэл төгрөгийн зардлыг төлүүлэх боломжтой.			
7. Малчин эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ сар бүр төлнө.			
8. Эрүүл мэндийн даатгалын сангаас даатгуулагчид эмийн үнийн хөнгөлөлт үзүүлнэ.			
9. Би эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сайн ойлгож, даатгуулсан.			
10. Би эрүүл мэндийн даатгалтай байсан. Шимтгэлээ хугацаанд нь төлж байгаа.			

Сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр

Хөтөлбөрийн зорилго: Нийгмийн даатгал, түүний ач холбогдлыг ойлгох, даатгуулах, даатгуулагчийн үүрэг, хариуцлагыг ухамсарлаж, эрхээ эдлэх мэдлэг, чадвар эзэмшинэ.

Хөтөлбөрийн зорилт:

- Нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийн заалтуудтай танилцах
- Нийгмийн даатгалын ач холбогдлыг ойлгож, даатгуулах арга замыг мэдэх, мэдлэгээ бусадтай хуваалцан түгээн сурталчлах
- Даатгалын шимтгэлийг тооцох, хугацаанд нь төлөх
- Тэтгэвэр, тэтгэмж авах болзлын дагуу тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг тооцох,
- Нийгмийн даатгалын тухай мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, баяжуулах

Зориулалт: Хөтөлбөрийг нийгмийн даатгалын талаар мэдлэг, чадвар эзэмшихийг хүссэн малчид, бусад хүмүүст зориулав.

Д/д	Дэд сэдэв	Агуулга	Эзэмших мэдлэг, чадвар
1	Нийгмийн даатгал	<ul style="list-style-type: none"> - Нийгмийн даатгал, түүний ач холбогдол; - Даатгуулагч, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, нийгмийн даатгалын төрөл ба сан гэх мэт үндсэн ойлголт, нэр томъёо; - Сайн дурын даатгал, - Нийгмийн даатгалд даатгуулах арга зам (журам); - Нийгмийн даатгалын шимтгэл төлөх хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын доод ба дээд хязгаар, шимтгэлийн хэмжээ; - Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр (өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны), тэтгэмж (хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын), - Тэтгэвэр, тэтгэмжийн хамгийн түгээмэл хэлбэр болох өндөр насны тэтгэвэр, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг авах болзол, хэмжээ, хугацааг бодох, тооцох дасгал ажил; 	<ul style="list-style-type: none"> - Нийгмийн даатгалын үндсэн ойлголтуудын талаар мэдлэг эзэмшиж, нийгмийн даатгалд даатгуулах, шимтгэл төлөх орлогынхоо хэмжээг сонгох, даатгуулагчийн хувьд үүргээ биелүүлэх, шаардлага тохиолдсон үед хүсэлт гаргаж тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах чадвартай болно. Өндөр насны тэтгэвэр, жирэмсний болон амаржсаны тэтгэмжээр жишээлэн тэтгэвэр, тэтгэмж тооцох талаар ойлголттой болно. Нийгмийн даатгалын тухай мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, баяжуулах дасгал хийнэ.

2	Эрүүл мэндийн даатгал	<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн даатгал түүний ач холбогдол; - Эрүүл мэндийн даатгалд хамрагдах арга зам, шимтгэлийн хэмжээ; - Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төр, эсвэл өөрөө төлөх даатгуулагч; - Эрүүл мэндийн даатгалд хамаарах эмчилгээ, үйлчилгээ, зардлын төлбөр; - Эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээ, түүний дээд хязгаар, хамтын төлбөр; 	<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн даатгалд даатгуулах, төлөх шимтгэлийн хэмжээ, хугацааг тооцох; - Авсан тусламж үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх, хяналт тавих; - Эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээ, түүний дээд хязгаараас хэтэрсэн тохиолдолд гэр бүлийнхээ нэг гишүүний зөвшөөрлөөр шилжүүлж болох эсэхийг тодорхойлох талаар мэдлэгтэй болно.
---	------------------------------	---	--

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэлбэр: Суралцагч зориулалтын гарын авлага, хэрэглэгдэхүүн ашиглан бие даан суралцах, богино хугацааны сургалт зохион байгуулж багшаар заалгаж сурах гэсэн хоёр хэлбэрээр хэрэгжүүлнэ. Аль ч хэлбэрээр хэрэгжүүлсэн суралцагчийн оролцоонд тулгуурласан идэвхтэй сургалтын аргыг хэрэглэнэ.

Ашиглах хэрэглэгдэхүүн: Уг хөтөлбөрөөр суралцахад ашиглах үндсэн хэрэглэгдэхүүн нь “Нийгмийн даатгал” хэмээх энэхүү гарын авлага бөгөөд бусад нэмэлт материалыг тухайн суралцах бүлгийн онцлогт тохируулан бэлтгэж хэрэглэнэ. Жишээ нь:

- Зураг, үзүүлэн
- Инфографик
- Тоо баримт
- Бодит жишээ, болсон явдал
- Хууль, журам, гэрээний загвар гэх мэт.

Мөн бусад зориулалтын гарын авлага, аудио, видео, кино зэрэг сургалтын хэрэглэгдэхүүн ашиглаж болно.

Үнэлгээ: Явцын өөрийн үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээ, үр дүнгийн үнэлгээний хэлбэрээр үнэлнэ. Явцын өөрийн үнэлгээ болон хөндлөнгийн үнэлгээ нь сургалтын явцад байнга хийгдэх ба үр дүнг нь суралцагч алдаа дутагдлаа залруулах, сургалтыг идэвхжүүлэхэд ашиглана. Сургалтын дараа суралцагч ямар үр дүнд хүрсэн, сургалтаар эзэмшсэн мэдлэг чадвараа амьдралд тогтвортой хэрэглэж, хөгжүүлж байгаа байдлыг үр дүнгийн үнэлгээгээр үнэлнэ.

**Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын талаар
мэдээлэл авах эх сурвалж**

Мэдээлэл авах сувгууд	Тайлбар
Нийгмийн даатгалын үйлчилгээний лавлах утас - 1800 -1289	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн мэдээлэл өгөгч-автомат хариулттай систем • 7 хоногийн 24 цагаар нээлттэй ажиллана. • Энгийн утасны тарифаар үйлчилнэ;
Мессежтэй лавлах 1900-1199	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн мэдээлэл өгөгч-оператортой харилцдаг систем • Нийгмийн даатгалын зөвлөх ажилтан ажилладаг.
http://www.ndaatgal.mn/regnd/	• 2006-2014 оны шимтгэл төлөлт, нэрийн дансны мэдээллээ и-мэйлээр авах боломжтой систем
http://www.ndaatgal.mn/rfcheck/	• Ажилласан жилээ нөхөн тооцуулах хугацаагаа баталгаажсан болон хэвлэгдсэн эсэхийг шалгах систем
http://www.ndaatgal.mn/emdprom3/	• Эрүүл мэндийн даатгалын урамшууллын үзлэгт хамрагдах эсэхийг шалгах систем
www.ndaatgal.mn	• Нийгмийн даатгалын байгууллагын үндсэн цахим хуудас
Фб/Нийгмийн даатгалын ерөнхий газар	• Нийгмийн даатгалын байгууллагын facebook хуудас
Шуудангийн хаяг	<p>Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар</p> <p>Улаанбаатар хот 15160, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо Бага тойруу 13/1, Утас: 976-11-328030</p>

**Нийгмийн даатгалын төв, орон нутгийн
байгууллагуудын хаяг, холбоо барих утас**

Байршил	Холбоо барих утас
Архангай аймаг	70332178
Баян-Өлгий аймаг	70422101, 70422785
Баянхонгор аймаг	70442162, 70443203
Булган аймаг	70342957
Говь-Алтай аймаг	70483483, 70483360
Дорноговь аймаг	70523159, 70523616
Дорнод аймаг	70583046, 70584128
Дундговь аймаг	70592285, 70594212
Завхан аймаг	70463820
Өвөрхайнгай аймаг	70323433
Өмнөговь аймаг	70533356
Сүхбаатар аймаг	70511351, 70511030
Сэлэнгэ аймаг	70363808
Төв аймаг	70273918
Увс аймаг	70452041
Ховд аймаг	70433046
Хөвсгөл аймаг	70382572
Хэнтий аймаг	70562261
Дархан-Уул аймаг	70377345
Орхон аймаг	70351334
Говьсүмбэр аймаг	70643011
Сүхбаатар дүүрэг	354200
Баянзүрх дүүрэг	452162
Баянгол дүүрэг	70149420
Чингэлтэйдүүрэг	312288
Хан-Уул дүүрэг	341615
Сонгинохайрхан дүүрэг	633259
Багахангай дүүрэг	0222244949
Багануур дүүрэг	70210281
Налайх дүүрэг	70232369



